

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ  
ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
2	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	4-50
	1.“Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	4-17
	2.“Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	17-50

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 15-ны  
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Ж.Ганбаатар, Л.Оюун-Эрдэнэ, М.Оюунчимэг, Х.Нямбаатар, Н.Энхболд.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Монгол Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахтай холбоотой загвар журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргав.

**Ж.Мөнхбат:** Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан

хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Золбоо Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, С.Бямбацогт, Д.Тогтохсүрэн, Г.Занданшатар, Ж.Мөнхбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Ц.Мөнх-Оргил, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш О.Мөнхсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, хэсэг, заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу санал хураалт явуулав.*

**Нэг.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийн талаар:**

**Ж.Мөнхбат:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Энэ хуулийн 22.2-т заасан дүн шинжилгээ, 22.3-т заасан дүгнэлтийг харгалзан шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал нэг дэх хэлэлцүүлгээс төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл өгч зөвхөн нэг удаа Засгийн газарт буцаана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	5
Бүгд:	12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“29 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол**

29.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонсгол явуулна:

29.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын албан

тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол;

29.1.2.хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол холбогдох Байнгын хороо албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцах сонсгол.

29.2.Нэр дэвшигчийн сонсгол нь баримт, мэдээлэлд үндэслэсэн, талуудын оролцоог тэнцвэртэй хангасан байх бөгөөд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуульд заасан бусад шаардлага хангасан эсэхийг нээлттэй хэлэлцэж, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэнэ.

29.3.Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.

29.4.Нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хууль, Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

29.5.Байнгын хорооноос нэр дэвшигчийн сонсгол /цаашид энэ бүлэгт “сонсгол” гэх/ явуулах үйл ажиллагаанд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

29.6.Нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, тухайн албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлага зэрэг мэдээллийг авах маягтын загварыг холбогдох Байнгын хороо батална.

29.7.Энэ хуулийн 29.6-д заасан загварт дурдсан мэдээллийг нэр дэвшигчээс өөрөөс нь гаргуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.2.Сонсголд холбогдох Байнгын хорооны гишүүдээс гадна Нийтийн сонсголын тухай хуулийн 10.2-т заасан оролцогчид оролцох бөгөөд тус хуулийн 15 дугаар зүйлд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.1.Түр хороо 5-19 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсгийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3, 37.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.2.Түр хорооны гишүүн гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл санаачилсан бол тухайн асуудлыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал хураалтаар цөөнх болсон гишүүн тухайн асуудлаар үндэслэлээ дэлгэрэнгүй тайлбарлаж, гурав хүртэл удаа санал хураалгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш О.Мөнхсайхан нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 1  
Бүгд: 12  
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.5 дахь хэсэг нэмэх:

“17.5.Улсын Их Хурал энэ хуулийн 17.4-т заасан тогтоол баталсан бол тухайн тогтоолд заасан хугацаанд Засгийн газар тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.7 дахь хэсэг нэмэх:

“19.7.Улсын Их Хурал энэ хуулийн 19.2, 19.6-д заасан тайланг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар зарчмын зөрүүтэй саналын 9 дэх саналыг гуравны хоёроор дэмжих горимын санал гаргав.

**Ж.Мөнхбат:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Мөнхбат:** 9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийг хасаж, дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар зарчмын зөрүүтэй саналын 10 дахь саналыг гуравны хоёроор дэмжих горимын санал гаргав.

**Ж.Мөнхбат:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Мөнхбат:** 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 2  
Бүгд: 12  
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар зарчмын зөрүүтэй саналын 11 дэх саналыг гуравны хоёроор дэмжих горимын санал гаргав.

**Ж.Мөнхбат:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 1  
Бүгд: 12  
91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Мөнхбат:** 11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 1  
Бүгд: 12  
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй 11 дэх санал дэмжигдсэн тул доорх саналаар санал хураалт явуулав.*

**Ж.Мөнхбат:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх.

2.Ажлын хэсгийн гаргасан, Хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй  
холбоотой найруулгын санал:**

**Ж.Мөнхбат:** 1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.5, 19 дүгээр зүйлийн 19.5, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “Төрийн аудитын” гэсний өмнө “Улсын Их Хурлын Тамгын газар болон” гэж, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “сонсголын тухай” гэсний дараа “болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хэсэг, түр хорооны” гэснийг “хэсгийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах” гэснийг “энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3.2

дахь заалтын “хэлэлцүүлгийн шатны” гэснийг “хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны” гэж, 23 дугаар зүйлийн гарчгийн “Төсвийн төслийн” гэснийг “Хоёр дахь” гэж, мөн зүйлийн 23.1, 23.4 дэх хэсгийн “Төсвийн төслийн” гэснийг “Хоёр дахь” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “явуулна” гэснийг “явуулж болно” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалтын “дүгнэлт, шаардлагатай бол тогтоолын төсөл боловсруулж” гэснийг “дүгнэлтээ” гэж, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “Цахим нотлох баримтыг бичмэл нотлох баримтад тооцно.” гэснийг “Бичмэл нотлох баримт нь цахим хэлбэртэй байж болно.” гэж, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “томилно. Хянан шалгагч томилох тухай түр хорооны тогтоолд хянан шалгагчийн ажлын даалгавар, шаардлагатай бол ажиллах хугацааг тогтооно.” гэснийг “томилж, ажлын даалгаврыг батална.” гэж, мөн зүйлийн 44.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 44.3.2-т заасны дагуу нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол хянан шалгагч энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтыг цуглуулах тухай тогтоол гаргуулах саналаа түр хороонд гаргана.” гэснийг “Хяналт шалгалтын явцад нотлох баримт гаргуулах шаардлагатай гэж үзвэл хянан шалгагч энэ хуулийн 37.1-д заасны дагуу тогтоол гаргуулах саналаа түр хороонд оруулна.” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “Хянан шалгах түр хорооны сонсголд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хуралдааны явцад дуу, эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.” гэснийг “Энэ хуулийн 46.2-т заасан оролцогчид сонсголын явцад дуу, эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Улсын Их Хурал хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/-тай байна.

5.2.Мэдээллийн нэгдсэн сан нь Улсын Их Хурлаас явуулсан хяналт шалгалтын холбогдох баримт бичиг, мэдээлэл болон хяналт шалгалтын бусад байгууллагаас гаргуулж авсан мэдээлэл, хууль тогтоомжид заасан бусад тогтмол мэдээллээс бүрдэх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн нэгдсэн сан олон нийтэд нээлттэй байна.”

“30.1.Байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсгол даргалагчийг сонгох бөгөөд сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална. Сонсгол даргалагч Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.3, 25.4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.3, 28.2.4 дэх заалтын “, түр” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн “, түр хорооны гишүүнийг томилох санал” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Мөнхбат:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсгийг ялгаатай болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.



Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 8  
Бүгд: 12  
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

### **Хоёр.Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**

*Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:*

*Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу санал хураалт явуулав.*

**Ж.Мөнхбат:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт буюу 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг нэмэх:

#### **2/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг:**

“12.4.Нэр дэвшигчийн сонсголд оролцогч гэж энэ хуулийн 10.2-т заасан оролцогчдыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 2  
Бүгд: 12  
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 23<sup>1</sup> дүгээр зүйл нэмэх:

#### **3/23<sup>1</sup> дүгээр зүйл.Сонсголын зардал**

##### **“23<sup>1</sup> дүгээр зүйл.Сонсголын зардал**

23<sup>1</sup>.1.Сонсгол зохион байгуулахтай холбогдон гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 2  
Бүгд: 12  
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, төслийн дугаар өөрчлөх:

**3 дугаар зүйл.**Нийтийн сонсголын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

#### **1/3 дугаар зүйл.Үндсэн болон тусгай зарчим:**

##### **“3 дугаар зүйл.Үндсэн болон тусгай зарчим**

3.1.Нийтийн сонсголыг зохион байгуулахад ардчилсан ёс, хууль дээдлэх, баримт, мэдээлэлд үндэслэсэн байх, талуудын оролцоог тэгш хангах, иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, үр нөлөөтэй байх үндсэн зарчмыг удирдлага болгоно.

3.2.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахад дараах тусгай зарчмыг баримтална:

3.2.1.нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандах;

3.2.2.нэр дэвшигч, оролцогчдод хүндэтгэлтэй хандах;

3.2.3.ил тод, нээлттэй байх.

3.3.Энэ хуулийн 3.2-т заасан тусгай зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно:

3.3.1.“нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандах” гэж нэр дэвшигчийн албан тушаалын болон бусад байдлаас үл хамааран асуултад хариулах, санал хэлэх боломжийг бүх нэр дэвшигчид тэгш олгох бөгөөд аль нэг нэр дэвшигчид давуу байдал олгохгүй байхыг;

3.3.2.“нэр дэвшигч, оролцогчдод хүндэтгэлтэй хандах” гэж албан тушаалын болон бусад байдлаас үл хамааран нэр дэвшигч, оролцогчоос асуулт асуух, үг хэлэхдээ хүндэтгэлтэй хандахыг;

3.3.3.“ил тод, нээлттэй байх” гэж нэр дэвшигчийн сонсголд оролцох хүсэлт гаргасан бол хуулийн үндэслэлгүйгээр татгалзахгүй байх, сонсголыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд, бүрэн дамжуулах, сонсголын тэмдэглэл ил тод байх, оролцогчид тэмдэглэлтэй танилцаж өөрийн саналыг хянах боломжтой байхыг.”

## **2/10 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол:**

### **“10 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол**

10.1.Энэ хуулийн 6.2.4, 6.2.7, 6.2.8-д заасан сонсголыг нэр дэвшигчийн сонсгол гэх бөгөөд тэдгээрийг зохион байгуулж, явуулахдаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай болон холбогдох бусад хуулийг баримтална.

10.2.Нэр дэвшигчийн сонсголд нэр дэвшигч, түүнийг Улсын Их Хуралд танилцуулах эрх бүхий этгээд, эсхүл түүний төлөөлөгч, нэр дэвшигчээс асуулт асуух, нэр дэвшигч нь тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсэх талаар санал хэлэх, мэдээлэл өгөхөөр хүсэлт гаргасан болон хуульд заасны дагуу мэдээлэл өгөх иргэн, хуулийн этгээд, ажиглагч оролцоно.

10.3.Нэр дэвшигчийн сонсголын асуулт, санал болон холбогдох мэдээлэл нь нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, туршлага, мэргэшил, ёс зүй, хараат бус, бие даан ажиллах чадвар, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлийн талаар байна.

10.4.Нэр дэвшигчийн сонсголотой холбогдуулан мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, иргэн, хэвлэл, мэдээллийн төлөөлөл оролцох хүсэлт гаргасан бол тэдгээрийг сонсголд заавал оролцуулна.”

## **3/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:**

“12.3.Сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих талаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг ажиглагч гэнэ. Ажиглагч нь сонсголын үед нэр дэвшигчээс болон бусад оролцогчдоос асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.”

#### **4/15 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүрэг:**

##### **“15 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүрэг**

###### **15.1.Сонсголд оролцогч дараах нийтлэг эрх эдэлнэ:**

15.1.1.энэ хууль болон холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх;

15.1.2.сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах;

15.1.3.сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах;

15.1.4.холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх эдлэх.

###### **15.2.Сонсголд оролцогч дараах нийтлэг үүрэг хүлээнэ:**

15.2.1.сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх;

15.2.2.сонсголын дэг сахих;

15.2.3.сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

15.2.4.сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх;

15.2.5.холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх.

15.3.Сонсголд оролцогч нь сонсголын явцад бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

15.4.Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.

15.5.Сонсгол зохион байгуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонсголд оролцох, ажиглах боломжийг хангана.”

#### **5/17 дугаар зүйл.Сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг:**

##### **“17 дугаар зүйл.Сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг**

17.1.Сонсгол даргалагч сонсголыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулах, сонсголын асуудлыг тал бүрээс нь үнэн бодитойгоор тогтоох, сонсголд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх, оролцогчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сонсголын дэг сахиулах үүрэгтэй.

17.2.Сонсгол даргалагчийг сонгох, томилох асуудлыг энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

17.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголын даргалагчийг Байнгын, дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.

17.4.Сонсгол даргалагч дараах нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

17.4.1.сонсголын бэлтгэлийг хангах;

17.4.2.сонсголыг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу явуулах;

17.4.3.сонсголд оролцож байгаа этгээдэд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;

17.4.4.сонсголын тайланг хянаж, эрх бүхий этгээдэд танилцуулах;

17.4.5.хүндэтгэн үзэх шалтгаантай оролцогчид чөлөө өгөх;

17.4.6.сонсголын дэг сахиулах, оролцогчдоос дэг сахицыг шаардах;

17.4.7.сонсголын дэг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах;

17.4.8.сонсголын асуулт, хариулт, тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох;

17.4.9.сонсголын дэг зөрчсөн, эсхүл энэ хуулийн 15.3-т заасан үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах;

17.4.10.сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх;

17.4.11.сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах.”

#### **6/18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг:**

“18.8.Сонсгол явуулах талаарх хүсэлт гаргах, тус хүсэлтийг шийдвэрлэх, сонсголын товыг зарлан мэдээлэх, сонсгол зохион байгуулах үйл явц, бүртгэл, сонсголын ирц, үе шат, сонсгол даргалагчийг сонгох, түүний эрх, үүрэг, сонсголын дэг болон сонсголын тэмдэглэл, тайлан гаргахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль<sup>1</sup> болон энэ хуулийн 18.7-д заасан журмаар нарийвчлан зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2  
Бүгд: 12  
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн” гэсний өмнө “мөн зүйлийн 18.7 дахь хэсгийн “батлана.” гэснийг “баталж болно.” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 18.9 дэх хэсэг, төслийн 3 дугаар зүйлийн “10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “нийт гишүүний дөрөвний нэгээс” гэснийг “есөөс” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулга бүхий 5 дугаар зүйл нэмэх:

**“5 дугаар зүйл.**Нийтийн сонсголын тухай хуулийн 11<sup>1</sup> дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:*

**Ж.Мөнхбат:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 15.33 дугаар зүйлийн гарчгийн “15.33 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтад саад учруулах” гэснийг “15.33 дугаар зүйл.Парламентыг үл хүндэтгэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6.Энэ зүйлийн 1-5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан болон Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан,

хуралдаан, сонсголд оролцсон этгээд дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:*

**Ж.Мөнхбат:** 1.Төслийн 3 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн” гэсний өмнө “8 дугаар зүйлийн 8.4.3 дахь хэсгийн “байгууллагад” гэснийг “байгууллага, Улсын Их Хуралд” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Мөнхбат:** “Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 58 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр 12 цаг 38 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.МӨНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Мөнхбат:** Гишүүд хуралдаандаа хүрэлцэн ирж ирц бүрдсэн учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр дөрвөн асуудал хэлэлцэнэ.

1.Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт нарын арван таван гишүүн 2021 оны 7 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан байж байгаа.

3.Монгол Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахтай холбоотой загвар журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан байгаа.

4.Бусад асуудал дээр сонгон шалгаруулах комисс байгуулах тухай байнгын хорооны тогтоолын төсөл, төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах үүрэг бүхий комисс байгуулна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Баатарбилэг, Батсуурь гишүүн. Баатарбилэг гишүүн

**Ё.Баатарбилэг:** Хэлэлцэх асуудалтай холбоотой ийм хоёр асуудал байгаа юм. Манай энэ Хяналт шалгалтын тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгтэй холбоотой Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл гээд хоёр дахь асуудал өнөөдрийн Байнгын хороонд орчихсон байгаа. Энийг долоо хоногоор хойшлуулах.

Хоёрдугаарт, Их Хурлаас нэр дэвшигчийн сонгон шалгаруулалттай холбоотой журам батлах тухай гэсэн Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Энэ хоёр манай энэ хэлэлцүүлэгтэй холбоотойгоор долоо хоног хойшлох шаардлага гараад байгаа учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлуулж долоо хоногоор хойшлуулж өгөөч гэсэн хүсэлт байна.

**Ж.Мөнхбат:** Энэ ажлын хэсгийн санал юм уу? Ажлын хэсгээс хэлэлцэх асуудлын хоёр, гурав дээр байгаа асуудлыг хойшлуулъя гэдэг санал гаргаж байгаа юм байна шүү дээ, тийм ээ? Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн Мөнх-Оргил 42 минут хоцорч Байнгын хорооны хуралдаанд ирсэн байна. Цаашдаа өглөөний түгжрэлээ бодож зохицуулж гэрээсээ гарцгааж байгаарай, Байнгын хороодын гишүүд. Батсуурь гишүүн горимын санал гаргая.

**Ж.Батсуурь:** Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, бусад хуулиудыг хэлэлцэх талаар Төрийн байгуулалтын байнгын хороогоор. Би хяналт шалгалттай холбогдуулж тусгайлан санал хэлэх гэсэн юм. Тэгэхээр сүүлийн үед энэ нийгмийн бухимдал бол маш их ихсэж байна. Та дөнгөж сая хэллээ, энэ түгжрэлээс авахуулаад өргөн хэрэглээний



барааны үнэ, бензиний үнийн асар их өсөлт, бензиний чанарын байдал, тэгээд хүний эрхийн асуудал, энэ шударга бус үйл ажиллагаа, утаа гээд. Энэ байдлыг нийгмийн дуу хоолойг илэрхийлэхэд цөөнхийн байр суурь бол байнга боомилгодож байх юм. Ингээд хараад судлаад үзэхэд энэ дуу хоолойг хэлэхэд хэвлэл мэдээлэл, энэ арилжааны телевизүүд бүгдээрээ амаа үдүүлчихсэн, сайт, сонингууд ерөөсөө хаалтын гэрээнүүд хийчихсэн. Тэгээд энэ үед бүгд л нэг ам нийлэн магтан дуулсан ийм үйл ажиллагаанууд явж байгаа юм.

Энийг хараад байхад нийгмийн дуу хоолойг илэрхийлж авахад бол би энэ үндэсний тодотголтой газруудын үйл ажиллагаа маш чухал гэж ингэж харж байгаа юм. Тэгэхээр яг энэ үед энэ Төрийн байгуулалтын байнгын хорооноос Үндэсний зөвлөлийг сонгодог, Монголын Үндэсний радио телевизийн үйл ажиллагаа ер нь ямар байна вэ гэдэг байр суурийг нь сонсвол яасан юм бэ? Ерөөсөө энэ ард түмний дуу хоолой ч дуугарахгүй юм, эрх баригчид чинь 40 гаруй хувийн саналаар нийт, өнөөдөр төрийн бүтцийг бүрэн барьж байна. Цаана нь 60 орчим хувь нь нийгмийн дуу хоолой ер нь нийгэмд гарч чадахгүй шүү дээ.

Өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал та хэдэн минут хойшилж эхэлж байгааг хэлж байна. Өчигдөр Төсвийн байнгын хороо юу болов? Тэгээд үндэсний аудитын газар дээр тэр зүйлийг шалгуулъя гэнгүүт тэр асуудлууд нь орж чадахгүй байна. Тэгэхээр мэдээж энэ Хяналт шалгалтын тухай хуулиуд бол ажлыг сайжруулах асуудлууд байж байгаа. Энэ хууль батлагдаад, тэгээд үйлчлээд хянаад шалгана гэх юм бол энэ нийгэм чинь хүлээх чадвар, тэвчээр байхгүй болчихоод байна.

Тийм учраас татвар төлөгчдийн мөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байгаа Монголын Үндэсний радио, телевиз ер нь өнөөдөр үйл ажиллагаагаа явуулж чадаж байна уу? Ард түмний дуу хоолой болж чадаж байна уу? Өнөөдөр тэр уулын мухарт байгаа, өчигдөрхөн ярьж байна Баян-Өлгий аймагт 80 бензин 3000 болчихсон байна шүү дээ. Тэгээд бензиний чанарын асуудлыг би өчигдөр гаргаж ирж ярьсан. Өнөөдөр банк бензин дээр бид нар Сүхбаатар аймаг ороод очоод хоёр хоног, өвөл ингээд хоёр хоног явдаг байсан бол банк бензинээр Багануурт ирээд дуусаж байна шүү дээ. Бензиний чанарын асуудал бүр 0 болчихсон байна. Энийг өчигдөр шалгуулъя гэхээр наадах чинь мэргэжлийн хяналтын газрын ажил, аудитын ажил гээд шалгахгүй болгочихно. Тэгэхээр яг энэ цаг дор ямар зүйл нийгэмд хэрэгтэй байна вэ гэхээр энэ Монголын Үндэсний радио, телевиз чинь татвар төлөгчдийн мөнгөөр үндэсний хэмжээний ард иргэдийн дуу хоолойг илэрхийлдэггүй юм уу? Бүгд магтан дуулагч болчихсон.

Тэр арилжааны телевиз нь яах юм бэ, мөнгөө аваад сайтууд нь дуугүй байя гэж бодъё. Үндэсний радио, телевизийн үйл ажиллагааг ерөөсөө магтан дуулдаг юм. Сөрөг хүчний байр суурь, үзэл бодлоо илэрхийлж байгаа хүмүүсийн байр суурь, нийгмийн болохгүй байгаа зүйлийг бол зөвхөн өнгө төдий гараад, наана нь текстээр арга хэмжээнд л байж байна шүү дээ. Энэ судалгаа Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад байна уу? Энэ үйл ажиллагааг хянадаг, шалгадаг, чиглэл өгдөг хүмүүс нь бол би Төрийн байгуулалтын байнгын хороо гэж ингэж харж байгаа. Тийм учраас энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга эрхийнхээ хүрээнд ойрын хугацаанд энэ Монголын үндэсний радио, телевизийн үйл ажиллагааг сонсож, хянаж шалгавал яасан юм бэ? Тайлан мэдээг нь үзвэл яасан юм бэ? Ард түмний дуу хоолойг хамгийн өмнө илэрхийлэх боломж бол эхлээд Монголын үндэсний радио, телевизэд байгаа гэж ингэж үзэж байгаа юм. Энийг та бас авч үзээч ээ гэж санал оруулж байна.

**Ж.Мөнхбат:** Батсуурь гишүүн санал гаргалаа. Тэгэхээр өнөөдөр бол бид нар хэлэлцэх асуудал дээр санал ярьж байгаа. Баатарбилэг гишүүн бол өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоотой хоёр, гуравдугаарт байгаа асуудлыг хойшлуулъя, долоо хоногоор гэсэн горимын санал гаргасан. Батсуурь гишүүн Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизтэй холбоотой саналыг гаргаж байна. Тэгэхээр яах вэ, энэ чинь Олон нийтийн радио телевизийн хуулиараа Төрийн байгуулалтын байнгын хороонд бас харьяалагдаж ингэж явж байгаа. Тийм учраас бол өнөөдрийн хэлэлцэх асуудал дээр Батсуурь гишүүн ээ, энийг оруулах боломжгүй байгаа. бид нар оруулна гээд шийдсэн ч энэ чинь тэр хүмүүс нь ирж, очих гэсээр байтал өнөөдөр багтахгүй юм болно шүү дээ. Тэгэхээр та албан ёсоор Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүний хувиар энэ саналаа Байнгын хороонд бичгээр Радио, телевизийн мэдээллийг сонсьё, дараагийн хуралдаан дээр энийг хэлэлцэх асуудалд оруулах боломж үүснэ. Тэгэхээр та албан тоотоор хүсэлтээ өгөөрэй гэдгийг хэлъе. Баярлалаа.

Ингээд хоёр горимын санал гарсан. Баатарбилэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Өнөөдрийн ажлын хэсгээс гаргасан санал шүү. Хэлэлцэх асуудлын хоёрдугаарт байгаа дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, гуравдугаарт байгаа Их Хурлаас нэр дэвшигчийн сонголт зохион байгуулахтай холбоотой загвар журам батлах тухай гэсэн энэ хоёр асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж, долоо хоногоор хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байна.

Горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт

11 гишүүнээс 9 нь дэмжиж, 81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёрдугаар асуудал, гуравдугаар асуудал долоо хоногоор хойшлогдож дараагийн долоо хоногийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд хэлэлцэхээр боллоо.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн тухай ажлын хэсгийн хуулийн ажлын хэсгийн ахлагч маань Сүхбаатар гишүүн байгаа. Дараагийн хуралдаан дээр ажлын хэсгийн ахлагч хариуцлагатай байж, өглөө цагтаа ирж, энэ асуудлуудаа Байнгын хорооны хуралдаан цаг хугацаанд нь хэлэлцүүлэхийг анхааруулъя.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт нарын арван таван гишүүн хоёр мянга хорин нэгэн оны долоон сарын хоёрны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Эцсийн хувилбар болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Янжинхорлоо Улсын Их Хурлын тамгын газрын хяналт шалгалтын үнэлгээний газрын дарга, Бямбадулам Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга, Мөнхсайхан Монгол Улсын их сургуулийн хууль зүйн сургуулийн багш гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хороо төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-ын 1 дэх хэсэгт заасны дагуу хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдох найман зарчмын зөрүүтэй саналын томьёолол, хамт өргөн мэдүүлсэн Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох зургаан зарчмын зөрүүтэй саналын томьёолол, хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах хуулийн төсөлтэй холбогдох хоёр зарчмын зөрүүтэй саналын томьёолол, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн үед хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь хэсэгт заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар дэмжих, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдох гурван зарчмын зөрүүтэй саналын томьёолол, нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед санал хурааж дэмжсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалт эшлэлийн найруулгыг нийцүүлж өөрчлөх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан холбогдох найруулгын дөрвөн багт санал, хамт өргөн мэдүүлсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох нэг саналаар санал хураасан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэр шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төв банк /Монгол банк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай

хуулийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хууль, тогтоолын төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа гэсэн Байнгын хорооны танилцуулга байна.

Та бүхэнд Байнгын хорооны танилцуулгыг уншиж танилцууллаа. Танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүн кнопоо дараарай. Бямбацогт гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүн асууя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Ийм л юм асуух гээд байгаа юм л даа. ингээд ажлын хэсэг дээр өчигдөр яриад 29.1.2 дээр ингээд оруулаад ирчихсэн байгаа юм, хуульд тусгайлан заасан эсвэл Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол холбогдох Байнгын хороо албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцах сонсгол гээд. Тэгэхээр 29.1.1 бол заавал хийх нь гэдэг нь ойлгомжтой болчхож байгаа юм. 29.1.2 дээр хуульд тусгайлан заасан бол мэдээж заавал хийнэ шүү дээ. Тэрийг оруулбал 29.1.1-дээ оруулмаар байгаа юм. Хуульд тусгайлан заачихсан бол, заавал сонсгол хийгээрэй л гэсэн бол 29.1.1 дээр тусгачихмаар байгаа юм.

Дараагийнх нь байна шүү дээ, Их Хурлын 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гарвал холбогдох Байнгын хороо албан тушаалтныг томилох гээд Их Хурлаас томилохгүй, Их Хурлын оролцоо байхгүй томилогдож байгаа албан тушаалтнуудын томилгоон дээр Их Хурал орох гээд байгаа юм шиг уншигдаад байгаа байхгүй юу. Жишээ нь Засгийн газар нэг агентлагийн даргаар томилж байлаа гэхэд тэрийг Их Хурал сонсгол хийж хэлэлцэж болохгүй шүү дээ. Их Хурал өөрийнхөө томилох хүмүүс дээр л сонсгол хийнэ үү гэхээс. Ийм том уут нээж болохгүй байх. 29.1.2, энийг ямар утгаар ингээд оруулаад ирэв, тайлбарлаад өгөөч.

Өргөн барьсан хуулийн төсөл дээр энэ 29, ер нь бол манай хуулийн амин сүнс бол энэ сонсгол дээр л байгаа юм л даа. Томилгоогоо л бид нар зөв хийгээд л яваад байх юм бол төрийн ажил жигдрээд л явчихна шүү дээ. Тэгээд энэ дээр энэ өргөн барьсан 30.1.2 дээр Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн албан тушаалд нэр дэвшигчийг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд санал болгосон тохиолдолд зөвшилцөх сонсгол хийнэ гэж байсан байхгүй юу. Тэгээд энэ байхгүй болчихоод байгаа юм. Энэ хаашаа орчихлоо? Энийг надад нэг хэлээд өгөөч. Баярлалаа. Би өчигдөр Архины хуулийн ажлын хэсэг хуралдуулж байгаад энэ ажлын хэсгийнхээ хуралд оролцож чадаагүй байхгүй юу. Тэгээд би тодруулж асуусан.

**Ж.Мөнхбат:** Мөнх-Оргил гишүүн Архины хуулийн ажлын хэсэгт ажилтай байсан учраас өчигдөр ажлын хэсгийн хуралдаа ороогүй. Өнөөдөр жоохон оройтсон юм байна, ойлголоо. Ингээд манай ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар гишүүн хүрэлцэн ирээгүй байна. Ажлын хэсгээс манай зөвлөх Болормаа хариулна. Ер нь бол бас нөгөө Мөнх-Оргил гишүүний Эрүүл мэндийн үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл гээд энд ороогүй боловч бас Улсын Их Хурлаас томилогддог хүмүүс байгаа шүү дээ. Болороо хариулах уу, ажлын хэсэг.

7 дугаар микрофон дээр ажлын хэсэг хариулъя. Хуульч Мөнхсайхан, Монгол Улсын их сургуулийн багш.

**О.Мөнхсайхан:** Баярлалаа, Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ нэр дэвшигчийн сонсгол бол Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн төслийн хамгийн чухал хэсэг. Тэгээд яг гишүүний сая тайлбарласнаар энэ 29.1.1-д жагсаасан албан тушаалд нэр дэвшихдээ заавал сонсгол явуулна. 29.1.2 дээр бол хуульд тусгайлан заасан бол бас заавал явуулна гэсэн агуулга байгаа. Тэгээд тэр есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол холбогдох Байнгын хороо албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцах сонсгол зохион байгуулна гэж байгаа маань зөвхөн Улсын Их Хурал томилох эсвэл Улсын Их Хуралд зөвшилцөхөөр эсвэл танилцахаар оруулж ирдэг тэр албан тушаалтнууд дээр сонсгол явуулах гэдэг агуулгаар байгаа. Тэгээд бичилт нь яг тэрийгээ илэрхийлэхгүй нөгөө Улсын Их Хурал руу ордоггүй хүмүүс дээр явуулах юм шиг ойлгож байвал найруулгын талаар сайжруулах боломжтой байх гэж бодож байна.

Улсын ерөнхий прокурорын хувьд бол энэ дагаж өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл та бүхэнд тараагдсан байгаа. Хорин нэгдүгээр хуудас дээр, энэ дээр санал болгосон нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо зохион байгуулна гээд заавал зохион байгуулахаар тэр хууль дээрээ бол байж байгаа юм. Энэ зөвшилцөх, танилцах дээр жишээлбэл, зөвшилцөх дээр Элчин сайдууд байгаа, Их Хурал руу орж ирж зөвшилцдөг. Энэ дээр бол заавал сонсгол явуулахаар заагаагүй. Гэхдээ Их Хурлын гишүүдийн есөөс доошгүй нь сонсгол явуулъя гэвэл тодорхой Элчин сайдын албан тушаалд нэр дэвшигч дээр хийх боломжтой байдлаар ингээд орсон байгаа.

Дээд шүүх бол Шүүхийнхээ тухай хууль дээр байгаа, угаасаа. Энэ оны 1 сард батлагдсан Шүүхийн хууль дээр Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдээ танилцах сонсголыг заавал хийхээр тусгасан учраас нөгөө хуульд тусгайлан заасан гэдгээрээ прокурор, Ерөнхий прокурор, Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч дээр сонсгол хийх нь бол тэрүүгээр зохицуулагдаад явчихсан учраас дахиж бичих шаардлагагүй гээд ингээд товчлоод орчихсон байгаа юм.

**Ж.Мөнхбат:** Мөнх-Оргил гишүүн тодруулах гэсэн үү? Манай ажлын хэсэг бас нэг юмыг анхаарчихмаар байна. ингээд засварын чанартай зүйл хийж байна шүү дээ, тийм ээ? Нэгэнт хуульд тусгайлан заасан гээд явах юм уу, бүр тодорхой болгож явах юм уу? Тэрийгээ нэг эргээд харах л хэрэгтэй юм байна даа. Мөнх-Оргил гишүүн нэмэлт 1 минут.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Хуульд тусгайлан заасан гэдэг нь энэ Шүүхийн хууль, Прокурорын хуулиудтайгаа яриад байгаа бол ингээд явчихад болох байх аа. Мөнхсайхан багшийн саяын өгсөн тайлбараас бол зөвхөн Улсын Их Хурлын оролцоотой томилгоо зөвшилцөх асуудлууд дээр л есөн гишүүн санал гаргах юм байна шүү дээ. Энийгээ тодруулмаар байгаа юм. Мөнхбат дарга аа, Мөнхсайхан багшийн ярьснаар тодруулчихмаар байна. Улсын Их Хурлын оролцоотой, Улсын Их Хурлын зөвшилцөөнтэй томилгоонууд. Тэгэхгүй бол яг энэ үсгээрээ орчих юм бол есөн гишүүн асуудал гаргаад л ямар ч албан тушаалтан дээр томилгооны сонсгол хийгээд байх бололцоо гарах гээд байгаа байхгүй юу.

**Ж.Мөнхбат:** Мөнхсайхан багш хариулъя тодруулаад. Ер нь энэ хуулийн агуулга чинь, зарчим бол Улсын Их Хурлаас томилогддог, зөвшилцдөг л албан тушаал дээр байгаа шүү дээ. Тэрийгээ бол сайн тодотгож л өгөх хэрэгтэй юм байна.

Нэгдсэн чуулган руу оруулахдаа бид нар янзлах хэрэгтэй юм байна шүү. 7 дугаар микрофон.

**О.Мөнхсайхан:** Тийм ээ, Мөнх-Оргил гишүүний яг сая хэлснээр ингээд тодруулаад найруулгын сайжруулсан байдлаар нэгдсэн хуралдаанд оруулах боломжтой гэж ойлгож байгаа. Баярлалаа

**Ж.Мөнхбат:** Ажлын хэсгийн Ганболд гишүүн нэмж тайлбарлая. Ажлын хэсгийн хуралдаанд бүтэн суусан гишүүн.

**Г.Ганболд:** Ажлын хэсэг дээр бид нар өчигдөр энэ дээр гол яригдсан юм бол яг саяын асуудал л даа. Дээр нь нэмээд ер нь ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн гишүүдээс нэлээн гарсан саналууд байгаа шүү дээ. Жишээлэх юм бол Үндсэн хуулийн цэцийн гишүүд байна, тийм ээ. Ерөнхийлөгчөөс орж ирдэг, Дээд шүүхээс орж ирдэг, Их Хурлаас ордог. Тэгвэл Дээд шүүхээс орж ирдгийг нь Дээд шүүх нь тэндээ тусдаа энэ сонсголоо хийдэг баймаар байна. Эсвэл юу гэдэг юм, Ерөнхийлөгчөөс орж ирж байгаа хүмүүс нь бол Ерөнхийлөгч өөрөө институцийнхээ хүрээнд тэр сонсголоо хийгээд орж ирсэн дээр нь бас Их Хуралд хүндэтгэлтэй хандахгүй бол нэгнийхээ орж ирснийг ингээд үгүйсгээд унагаад явах ийм хандлагууд байгаа учраас энэ зүйлүүдийг бас ингэж ярилцах ёстой шүү гэдэг дээр бас нэлээн тиймэрхүү зүйлүүд гарсан гэдгийг би хэлэх гээд байгаа юм. Энэ дээр бас манай энэ бусад гишүүд маань ямар байр суурьтай байгааг би бас заримдаа нэг талаасаа бодох л асуудал юм байна.

**Ж.Мөнхбат:** Бямбацогт гишүүн асууя.

**С.Бямбацогт:** Хоёр асуулт байгаа юм. Нэгдүгээрт нь, энэ бидний өргөн барьсан төслийн 25.3 дээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрэх ажиллагаанд байгаа асуудлаар хяналтын сонсгол явуулахыг хориглоно гэсэн заалт байсан. Энэ заалт хасагдаж байгаа юм байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах, шүүн таслах үйл ажиллагаанд хууль тогтоох байгууллага оролцоо байх нь бас зохимжтой биш байх гэсэн үндэслэлээр уул нь энийг өргөн барьсан байсан. Байнгын хороон дээр бас яригдсан, ажлын хэсэг дээр бас яригдсан байх. Чуулганаас яригдаж байсан. Зайлшгүй асуудлуудаар эрүүгийн хэрэг үүссэн гээд л нуугаад дараад хэлэлцэхгүй байгаад байх ийм тал гарах юм байна гэдэг үндэслэл бас яригдаж байсан. Энэ дээр манай ажлын хэсэг маань хэрхэн яаж анхаарч ажилласан бэ? Энийг нэгдүгээрт нь хариулж өгөөч.

Хоёрдугаарт нь, хуулийн хэрэгжих хугацаатай холбоотой хуулийг ердийн журмаар батлаад хэрэгжүүлэх гээд байна уу, эсхүл хугацаа, бэлтгэл ажил гээд хойш нь тавих гээд байна уу? Миний бодлоор бол ердийн журмаар хэлэлцээд аль болох л Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм. Засгийн газар өчигдөр бас шийдвэр гаргасан байна лээ. Төрийн хяналт шалгалтыг 50 хувь цөөрүүлнэ гэж. Гэхдээ төрийн хяналт шалгалт гэдэг маань энэ дээр тодотгохдоо бол хувийн хэвшил, ард иргэдийн үйл ажиллагаатай холбоотой хянадаг, шалгадаг, дарамталдаг торгодог шийтгэдэг энэ байдлыг энэ цар тахлын үед, эдийн засгийн хүндрэлтэй үед больё. Ард иргэдээ л болох дарамтлахгүй байя, торгохгүй байя, аж ахуйн нэгжээ боомилохгүй байя. Эдийн засгаа дэмжье, татвар төлөгч, баялаг бүтээгчдээ дэмжье гэсэн бодлого гаргасан байна лээ. Энэ бол зөв.

Хамгийн гол нь төрийн хяналт шалгалт нэрээр төрийн албан тушаалтнууд маань хуулийг хэрэгжүүлдэггүй, хуулийг завхруулдаг, хуулийн нэрээр айлган сүрдүүлдэг, дарамталдаг шахдаг. Үүнийхээ цаад талд нь авлига, шан харамж авах гэж оролддог ийм асуудал байгаад байгаа юм л даа. Тийм болохоор төрийн гаргаж

байгаа бодлого, төрийн хуулийг хэрхэн яаж хэрэгжүүлж байна гэдэг дээр төрийн албан хаагч нар дээр, ялангуяа төрийн дунд шатанд нэлээн сайн Улсын Их Хурал хяналтаа тавих ёстой, хяналтаа тавих ёстой. Энэ үүднээсээ төрийн бодлогыг хэрэгжүүлж байна уу, хэрэгжүүлэхгүй байна уу, зөв хэрэгжүүлж байна уу, буруу хэрэгжүүлж байна уу гэдэг дээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар бид нар гүйцэтгэх засаглал, энэ төрийн дунд шатны албан тушаалтнууд дээр хяналтаа тавих ёстой. Ард иргэд рүү хяналт тавих гээд байгаа юм биш. Тийм учраас энэ хууль маань цаг хугацаандаа хэрэгжээд явмаар байна. Улсын Их Хурал бодлого гаргадаг. жишээ нь утааны асуудал байж байна шүү дээ. Утаатай тэмцэх гэж хэчнээн олон жил юу боллоо. Тодорхой үр дүн гарсан. Улсын Их Хурал нь, Засгийн газар нь, орон нутгийн засаг захиргаа нь анхаарсан үр дүн гарсан Улаанбаатар хотод.

Гэтэл өнөөдөр ингээд л, эргээд нөгөө төрийн хууль бодлого маань хэрэгжихгүй, үүнээсээ болоод, хоёр жил утаагүй Улаанбаатарт амьдарч чадсан мөртөө өнөөдөр эргээд л бөөн утаан дунд амьдарч байна. Ийм байдлаар төрийн албан тушаалтнууд ажлаа хариуцлагагүй хийж байгаа. Энэ дээр төрийн хяналт шалгалт ажиллах ёстой. Энэ бол ард иргэдийн буруу биш, хувийн хэвшлийнхний буруу биш, энэ төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ёстой, зохион байгуулах ёстой албан тушаалтнуудын буруу. Энийг бид нар яагаад шахаж шаардаж болохгүй гэж? Ийм асуудал дээр хуулийг хэрэгжүүлэх хугацааг болон ердийн журмаар л хэлэлцмээр байх юм. Энийг хэрхэн яаж ярьсан юм бол оо? Би хойшлуулах гээд байсан сураг сонссон.

**Ж.Мөнхбат:** Бямбацогт гишүүний ярьж байгаа бол тийм үнэн. Ер нь бол энэ төрийн хяналт шалгалтыг бид нар бас цэгцтэй болгох хэрэгтэй. Тийм учраас Засгийн газраас төрийн хяналт шалгалтыг 50 хувийг цөөлнө гэдэг бол хувийн хэвшил, аж ахуйн нэгж, ард иргэдийг хянадаг, шалгадаг юмыг цөлж байх шиг байгаа юм. Жишээлбэл мэргэжлийн хяналт ч гэдэг юм уу. Гэтэл энэ төрийн байгууллагууд болон төрийн энэ албан тушаалтнуудыг үйл ажиллагаа нь хуулийн дагуу байна уу, хууль хэрэгжүүлж байна уу гэдэг юмыг энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулиар бид хянадаг, шалгадаг. Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллагын хувьд ингэж явна. Тэгэхээр ердийн зарчмаар хууль хэлэлцэгдэнэ. Эцэслэн батална, ирэх долоо хоногт. Тэгээд хоригийн тав хоног, тэрийгээ дуусгаад “Төрийн мэдээлэл” сэтгүүл дээр хэвлэгдээд, ингээд л энэ хууль хэрэгжинэ гэсэн ийм ойлголттой чигтэй явж байгаа шүү. Ажлын хэсгээс өөр янз бүрийн санал гаргаагүй биз дээ, манайхан? Хэлэлцэх дээр ердийн зарчмаар хэлэлцье гэж байгаа биз дээ тийм ээ? Бямбадулам 7 дугаар дугаар микрофон.

**Ж.Бямбадулам:** Энэ өргөн баригдсан хуулийн төсөл бол ердийн журмаар батлагдахаар хуулийн төсөлдөө тусгагдсан байгаа. Анхны хэлэлцүүлгээр бол дагаж мөрдөх хугацааны тухай асуудал гарсан боловч ердийн журмаараа явах нь зүйтэй гэж Байнгын хороон дээр үзсэн, ажлын хэсэг дээр. Дараа нь эцсийн хэлэлцүүлгийн өмнө хуралдахдаа бол энэ талаар тодорхой санал гараагүй байгаа.

**Ж.Мөнхбат:** Тогтохсүрэн гишүүн асууя.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Би өмнөх анхны хэлэлцүүлэг дээр нэг асуудал байсан. 48.2. Тэр юу байна вэ гэхээр Түр хорооны гишүүдийн гуравны хоёр нь гэрч дуудах, нотлох баримт бүрдүүлэх, шинжээч ажиллуулах ийм санал гаргавал гишүүд шууд шийдэхээр байсан юм. Тэрийг би олонхын саналаар ингээд оруулсан. Тэрний дараа тэр нь цаашаа яаж шийдэгдэх вэ гэдгийг Цэц рүү гэдэг байдлаар бид нар анхны хэлэлцүүлэг дээр тохирсон юм. Тэрийг анхны хэлэлцүүлэг дээр нэгдсэн чуулган дээр ярилцаад дарга чиглэл өгөөд дахиж боловсруул гэдэг ийм

чиглэл өгсөн. Энийг нэгдүгээрт яаж ажлын хэсэг тогтсон бэ? Энэ их чухал асуудал байгаа юм.

Хоёрдугаар асуудал нь бид нар нийтийн сонсголтой холбоотой асуудлыг ярьж байгаа. Түрүүн олон гишүүн хэлж байна лээ. Тэгээд энэ дээр нэг ийм л юм байгаа юм. Нийтийн сонсгол хийчхэж байгаа юм. Хийх бол амархан байгаа юм. Гэтэл нийтийн сонсголын үр дүн гээд нэг юм баймаар байгаа юм. Нийтийн сонсгол дээр ёс зүйн асуудал маш их яригддаг, алдаа дутагдлууд яригддаг. Хууль зүйн асуудал хүртэл яригддаг. Ямар нэгэн гэмт хэрэгт холбогдож байсан асуудал яригддаг. Тэгээд дараа нь энэ ямар ч үр дүн байхгүй, нэг баахан яриад л өнгөрдөг. Үнэхээр ёс зүйн хувьд зөрчил гаргачихсан, ямар нэгэн гэмт хэрэг төвөгт холбогдчихсон, энэ олон түмэн дэмжихгүй байгаа ийм нөхрийг тэгээд л нэг жаахан ярьж байгаад л явуулчихаад байгаа байхгүй юу. Эсвэл зөв зүгээр хүнийг нэр төрд нь халдаж, халдаж, навс навс болгож өгөөд л дараа ажиллахад хэцүү болгож өгөөд л, тэгээд явуулчихаж байгаа байхгүй юу. Энийг ер нь цаашдаа нийтийн сонсгол хийхийн өмнө иргэдээс ирсэн энэ гомдлуудыг тогтоох энэ юман дээр ер нь энэ хуулийн төсөл дээр тусгагдаж байгаа юм байна уу? Би Мөнхсайхан багшаас л асууя гэж бодоод байгаа юм.

Тэгээд бид чинь нийтийн сонсгол хийх жишиг гаргаад байгаа. Нийтийн сонсголоо хийгээд эхлэхээр иргэдийн зүгээс, хэрэглэгчдийн зүгээс маш их хэмжээний гомдол ирдэг. Ихэнх нь ёс зүйн гомдлууд байдаг. Зарим нэг нь ажил хэргийн алдаа дутагдлын гомдол байдаг. Гэтэл энэ нь тогтоогддоггүй тэгээд жаал ярьж, ярьж байгаад л байдаг. Эсвэл ямар нэгэн зохион байгуулалттайгаар нэг хэсэг бүлэг хүмүүс нэг нэгээ гэвж өгдөг. Тэгээд тэр нь дараа нь ажиллахад нь ажлынх нь нэр хүндэд нөлөөлдөг юмнууд чинь гарч ирчих гээд байгаа юм. Энэ хоёр юмыг ер нь яаж зааглаж цаашдаа зөв авч явах юм бэ? Хэрэв үнэхээр ёс зүйн болон ажил албаны дутагдалтай хүнийг тэгээд нэг жаал шүүмжилж өгөөд явуулаад байх юм уу? Энийг болиулдаг, буцаадаг дараагийн хүнийг нэр дэвшүүлдэг ийм асуудал байна уу гэсэн ийм зүйлийг асууя.

**Ж.Мөнхбат:** 7 дугаар микрофон, Мөнхсайхан багш хариулъя. Асуулт ойлгомжтой тийм ээ?

**О.Мөнхсайхан:** Хуучин өргөн барьсан төслийн 48.2 та бүхэнд тараагдсан зарчмын зөрүүтэй. Төслийн 37.2 Тогтохсүрэн гишүүний эхний асуулт дээр өөрөөр хэлбэл, өргөн барьсан төслөөр Хянан шалгах түр хорооны гишүүдийн дөрөвний нэгээс доош хүн нь санал гаргах юм бол гэрчээр дуудах, нотлох баримт гаргуулах зэрэг ажиллагааг шууд хийхээр төсөл өргөн баригдсан. Энэ дээр бол гишүүдийн санал бол энэ бас урвуулан ашиглагдах эрсдэлтэй гэдэг үндэслэл бол яригдаад хүлээн зөвшөөрөгдсөн. Тэгээд Хоёр дахь хувилбар Австри, Герман зэрэг улсад байдагтай адилхан Түр хорооны гишүүдийн цөөнх нь нотлох баримт авъя гэхэд олонх нь татгалзах юм бол тэр нотлох баримт нь тэр хянан шалгалтын сэдэвт ач холбогдолтой эсэхийг нь Үндсэн хуулийн шүүх юм уу, Дээд шүүхээрээ таслуулдаг ийм жишиг байдаг. Тэрүүгээр бол өмнөх тэр нэгдсэн хуралдаан дээр орсон боловч чиглэл аваад засаж сайжруулах ийм даалгавар ажлын хэсэгт ноогдсон.

Энэ яг Цэц рүү хандаж хагалуулах асуудал бол дараа нь Цэцийн тухай хууль тогтоомж шинэчлэн найруулагдах хүрээнд цогцоор нь яригдах юм байна гэж бол ажлын хэсэг дээр яригдсан учраас дараа энэ зүйл хэрвээ орохоор бол тэр хүрээнд яригдана гэж ойлгосон. Яг одоогоор бол Тогтохсүрэн гишүүн, Энхболд гишүүн нарын саналаар энэ 37.2 дээр бол Түр хорооны гишүүн гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл санаачлах юм бол хуралдаанд оролцож байгаа гишүүдийнхээ олонхоороо тэрийг шийдвэрлэнэ. Гэхдээ



бас цөөнх болсон гишүүд нь гурав хүртэл удаа үндэслэлээ тайлбарлаж, олонхдоо учир холбогдлоо хэлж санал хураалгах эрхийг нь нээсэн байдлаар энэ томьёолол бол яг гишүүдийн саналаар бол ингээд тусгагдчихсан явж байгаа.

Хоёр дахь асуултын хувьд бол энэ сонсголын үр дүн байгаа юм. Ер нь сонсгол маань өөрөө тухайн нэр дэвшигч албан тушаалд тавигдах шаардлага хангаж байна уу, үгүй юу гэдгийг илүү тал, талын мэдээллийг авч нягтлах, их яаруу биш, бас тодорхой хугацааг гаргаж судлах, Их Хурлын гишүүд маань тэр саналаа өгөхдөө бол илүү мэдээлэлтэйгээр санал өгөх тэр боломжийг олгож байгаа. Нөгөө талаас иргэдийн мэдэх эрхийг нь хангаж өгч байгаа.

Энэ дээр яригдаж байгаа асуудал бол тухайн албан тушаалд тавигдаж байгаа шаардлагыг хангасан эсэх бол эрүүгийн гэмт хэрэгт буруутгагддаг тийм өндөр стандарт бол тавьдаггүй. Эрүүгийн хэрэг дээр бол 90-ээс дээш хувиар жишээлбэл, үндэслэл бүхий эргэлзээгүйгээр гэм бурууг нь нотлох асуудал яригддаг. Гэхдээ тэр түвшний биш ч гэсэн эргэлзээтэй. Тэр үндэслэл мэдээлэл аль аль талаасаа гардаг. Тэрийг нь хэлэлцдэг. Тэгээд дараа долоо хоногт хэлэлцэхээр хойшлуулчихсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуульд бол сая Тогтохсүрэн гишүүний хэлсэн асуудлыг анхаарсан ийм зарчмын заалтууд байгаа. Тухайлах юм бол нэр дэвшигчийг дэмжиж байгаа талын санал байх юм бол тэрийг няцаасан тэр санал байр сууриудыг тэнцвэртэй сонсоно гэдэг хэтэрхий нэг тал руу нь бас хазайх тэр асуудлыг хязгаарласан тийм зохицуулалтууд байж байгаа.

Гол нь бол сонсгол хийсний дараа хэрвээ Их Хурал томилж байгаа тохиолдолд томилох эсэх дээрээ Их Хурлын гишүүд маань тэр сонсголын үр дүн, тайланг харгалзаж саналаа өгөх. Зөвшилцөж байгаа тохиолдолд энд прокурор дээр ерөнхийлөгч тэр хүнийг томилох эсэх дээр жишээлбэл, дараагийн хүн оруулж ирэх байдлаар, эсвэл танилцах сонсгол дээр бол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч дээр Их Хуралд танилцаад асуудлууд яригдлаа гэхэд Ерөнхийлөгч тэр яригдсан асуудлыг шийдвэр гаргахдаа харгалзах ийм боломж бол байж байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комисс дээр жишээлбэл, сонсгол хийгээд нэлээн ноцтой асуудлууд яригдаад, тэр нь өөрөө тэр ажлын хэсгээс нэр дэвшүүлэх дээр.

**Ж.Мөнхбат:** 7 дугаар микрофоныг нэмж өгье.

**О.Мөнхсайхан:** Тэгэхээр ийм байдлаар бол үр дүн нь бол хэрэгжиж байгаа. Тэгээд энэ төсөл маань бол бас олон улсын сайн туршлагаас гадна өнгөрсөн хугацаанд хийгдсэн сонсголуудыг бас сургамжуудыг нэлээн харгалзаж тусгахыг. Сая сүүлийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ үзсэн. Хүний эрхийн Үндэсний Комисс, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч зэрэг дээр. Тэр нь бол нарийн дэг дээрээ орчихсон байгаа. Түрүүн бас Ганболд гишүүн сөхөж ярьсан нэг зүйлийг бас хэлэх нь зүйтэй байх аа.

Ер нь сонсголыг тэр санал болгож байгаа албан тушаалтан хийж болох юм уу гэдэг асуудал бол манай энэ дэд ажлын хэсгийн зарим гишүүдийн зүгээс бас гаргаж тавьсан. Гэхдээ ажлын хэсэг бол тэрийг бол сонссон. Гэхдээ яагаад энэ төслөөрөө явж байгаа вэ гэхээр энэ бол парламент гэдэг бол ард түмний төлөөллийн байгууллага. Ард түмнийг ер нь бол зөвхөн парламент л төлөөлж чаддаг. Яагаад гэхээр парламент бол тэр ард түмний олон өөр өөр хэсгүүдийг төлөөлж байдаг учраас. Тэгээд ил тод байдал нь хангагддаг нарийн процедуртай. Тэгэхээр ер нь бол сонсгол ихэнх тохиолдолд парламентын оролцоотой тохиолдолд парламент руу орж ирж байгаа бол парламент дээрээ сонсгол хийдэг ийм олон улсын жишиг байдаг.

Жишээ нь Ерөнхий сайд ч байдаг юм уу, Ерөнхийлөгч байдаг юм уу, сайд ч байдаг юм уу, тодорхой албан тушаалтан ялангуяа тэр гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалтан сонсгол хийнэ гэдэг бол өөрөө төдийлөн энэ ил тод нээлттэй байх, оролцоог хангах дээр бол учир дутагдалтай байдаг. Тэгэхдээ бол тэр хүмүүс санал болгохдоо нэлээн сайн судалж байгаад шалгуурыг хангасан ийм дэлгэрэнгүй мэдээлэл судалгаан дээрээ үндэслэж нэр дэвшүүлэх үүрэг нь байж байгаа. Бас нэг зүйл энэ нэр дэвшигчтэй холбоотой асуудал сөхөгдөөд, иргэдээс гарлаа гэхэд тэрийг нягталж судлах ийм боломжийг бас дараа долоо хоногт хэлэлцэх дэгийн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтөөр явж байгаа юм.

Тухайлах юм бол тухайн чиглэлийн мэргэжлийн холбоо эсвэл тусгайлсан мэргэжилтнийг шинжээчээр томилоод, энэ олон нийтийн сөхөж тавиад байгаа асуудлууд үнэн бодитой юу, ер нь тэр нэр дэвших шаардлага хангасан уу, үгүй юу гэдэг дээр бас дүгнэлт гаргуулах боломжийг Байнгын хороонд өгсөн. Тэгэхээр тэр дүгнэлт бол эргээд гишүүдэд тус болох ийм боломж байгаа. Баярлалаа.

**Ж.Мөнхбат:** Тэр шалгуурт нь нийцэхгүй, зарчимд нийцэхгүй хүн нэр дэвшээд орж ирлээ. Тэгээд баахан ярилцаж ярилцаж, шүүмжилж, шүүмжилж, тэгээд ямар нэгэн алхам хийх боломж нь нээлттэй байгаа юм уу? Татгалзах, түдгэлзэх, хойшлуулах юу гэдэг юм? Мөнх-Оргил гишүүн ажлын хэсгээс тайлбарлая гэж байна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Тэр Ерөнхийлөгч Дээд шүүхээс жишээ нэр дэвшүүлээд Улсын Их Хурал дээр санал хураалгахад Улсын Их Хурал дээр сонсгол хийх биш Дээд шүүх, Ерөнхийлөгчийнхөө Тамгын газрын түвшинд хэлэлцүүлэг хийчихвэл яадаг юм гэдэг саналыг ажлын хэсэг дээр ярьсан л даа. Тэгэхдээ бидний барьж байгаа байр суурь, ер нь энэ Их Хурлын барьж байгаа байр суурь бол эцсийн томилгоог Улсын Их Хурал хийж байгаа учраас, шийдвэрийг нь Улсын Их Хурал гаргаж байгаа учраас тэр шийдвэр гаргаж байгаа байгууллага дээрээ сонсголоо хийх нь зөв гэж үзэж байгаа юм. Нэр дэвшүүлж байгаа хүн бол мэдээж тэр хүнээ судална шалгана, зөв хүнээ оруулж ирнэ. Тэр хүн нь Улсын Их Хурлын босгыг давах уу, үгүй юу гэдэг нь Улсын Их Хурлынхаа сонсголоор шийдэгдэж байх ёстой юм гэж ярьсан юм.

Сонсголын үеэр жишээ нь сая энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийн асуудлаар сонсгол явуулаад, ингээд тэр хүмүүсийн тухай асуудал гарч ирээд байхад тэр хүмүүсийг цааш нь явуулчихаад байна, энэ сонсголын хэрэг байна уу, үгүй юу гэдэг асуудал яригдчихсан боллоо л доо. Тэгэхээр энэ дээр хоёр талтай байгаа юм. Тухайн нэр дэвшигчдийн талаар янз бүрийн асуудал гаргуулах гэж л, хов юу, үнэн худлаа нь мэдэгдэхгүй янз янзын юм ярьж байхын оронд сонсгол дээр тэр хүмүүсийн тухай асуух асуултыг нь асуугаад материалыг нь цуглуулаад нийтэд ил тод болгоод, тэгээд тэндээ тэр материал дээрээ үндэслэж тэр материалыг л дэнслэх асуудал байгаа, Улсын Их Хурлаар.

Сая Хууль зүйн байнгын хороон дээр жишээ нь энэ Сахилгын хороо, Ерөнхий зөвлөлийн гишүүдийн асуудлаар бид нар нээлттэй сонсгол хийсэн, маш олон асуудлууд ирсэн. Тухайлбал нотариатын байгууллагад ажиллаж байсан нэг хүн нотариатын үйлдлийг буруу хийсэн гэсэн маргааны асуудал, ёс зүйн асуудал ярьж байгаа байхгүй юу. Энийг бид нар тал талаас нь үзээд нотариатын байгууллага, Хууль зүйн яамнаас дүгнэлтүүд гаргуулаад, эрх зүйн дүгнэлтүүд гаргуулаад тэр хүн тухайн үед үйлдлээ хууль номын дагуу хийжээ гэдгийг нь бид нар жишээ нь Байнгын хороон дээрээ ярьж байгаа байхгүй юу. Тэгээд өөр өөрсдийнхөө итгэл үнэмшлээр энэ хүн бол үйл ажиллагаагаа зохих журмын дагуу хийжээ, ёс зүйн алдаа гаргаагүй юм байна гэж үзээд л бид нар цааш нь явуулж байгаа байхгүй юу. Тэрнээс биш

сонсголын үеэр асуудал гарсан хүн болгоныг бид нар заавал буруутгах бололцоогүй шүү дээ.

Энэ дээр дараа нь энэ нэг санал хураалгах гуравны хороор босгох санал байгаа юм, дарга аа, тэрийгээ дараа нь хэлчих үү?

**Ж.Мөнхбат:** Их Хурлын дарга асуулт асууя гэсэн үү?

**Г.Занданшатар:** Энэ ажлын хэсгээс нэг асуулт байгаа юм. Яг энэ анх нийтийн нээлттэй сонсголын журмыг баталж байхад 2016 онд investigate буюу мөрдөн шалгах нээлттэй сонсголыг манай Үндсэн хуульд нийцэхгүй гээд зарчимд нийцэхгүй байх гээд тэр мөрдөн шалгах нээлттэй сонсголыг нээлттэй сонсголын журмаас хасчихсан юм. Тэгэхээр нээлттэй сонсгол бол одоо зөвхөн, Улсын Их Хурлын гишүүд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл нь илүү давамгайлсан тийм парламентын аргачлал болсон. Энэ шүүлтүүрийн хэлбэр болохоос биш ингээд болгоомжлоод байгаа юм шиг нээлттэй сонсголоор шийдвэр гарахгүй байгаа шүү дээ. Тэрэн дээрээ үндэслэж л гишүүд дэмжих үү, дэмжихгүй юу гэсэн шийдвэр гаргах зарчим гэж ойлгох хэрэгтэй.

Түүнээс биш ёс суртахуун, хэрэг зөрчил шаардлагатай бүх мэдээллүүд харанхуйгаар дэмждэг тийм шийдвэр гаргадаг байсан бол, энийг л бий болгож байгаа арга, ардчиллын илүү л арга гэж энэ нээлттэй сонсголыг оруулсан шүү дээ. Энийг ингээд нэг сулруулаад юм уу, нэг чангаруулаад, эцсийн үр дүндээ гишүүд л эцсийн шийдвэрийг гаргана. Тэр нь үнэхээр серьёзны томоохон асуудал байх юм бол яалт ч үгүй нийгмийн шаардлагаар тэр томилгооны сонсгол дээр бол унагаах асуудал гарна. Бусад зөрчил нь бол ингээд эцсийн дүндээ бүх асуудлыг Их Хурлын гишүүдийн кноп, саналаар шийдэж байгаа шүү дээ. Тийм учраас мөрдөн шалгах сонсголын юмыг цаана нь та нар юу гэж бодсон бэ? Эхний төслөөсөө хассан.

Хоёрдугаарх нь, бол Улсын Их Хурлын дарга ингэж санал болгоод л Монголбанкны Ерөнхийлөгч ч юм уу, энэ Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалуудыг бол өмнө нь ингээд л гар өргөөд л батлаад явчихдаг байсан юм. Тэгэхээр Улсын Их Хурал энийгээ бол илүү нээлттэй болгож бүгдийг нь нээлттэй сонсголд оруулж байгаа юм. Их Хурлын дарга нэр дэвшүүлээд л томилогддог байсан бүх албан тушаалтнуудыг нээлттэй сонсголд заавал оруулдаг болж байгаа. Тэгтэл бусад албан тушаалтнууд дээр ч гэсэн зөвшилцдөг. Одоо ингээд нээлттэй сонсгол нэг их буруу биш байсан гэдэг нь өнгөрсөн хугацаанд харагдаж байна шүү дээ. Захын хүн, дурын хүн, нэг хүн карманаасаа гаргаж ирээд томилогдчихдог байсан юм бол халагдлаа. Хүний эрхийн Үндэсний Комисс ч тэр, шүүхийн болон бусад холбогдох албан тушаалтнууд Их Хурлаас.

Тэгтэл прокурор ч юм уу, бас энэ зөвшилцдөг албан тушаалтнууд дээр энийг харгалзан үзэх шаардлага гарах уу, серьёзны асуудал. Бусад улсын туршлага бол ийм байна л даа. Investigate public arrang ч гэж маань, зөвшилцдөг, Ерөнхийлөгчид нэр дэвшүүлдэг албан тушаалтнууд дээр ч тийм байна, Солонгост, прокурор ч байдаг юм.

Гуравдугаарт нь энэ юуны асуудал байгаа юм. Гуравдугаарт нь манайхан албан тушаалтнуудын томилгооны сонсгол дээр баримт мэдээллүүдийг л ил болгоход хангаж байгаа юм чинь тэр нээлттэй, Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийж байгаад дэлхийн бараг бүх улсын хяналт шалгалтын эрх мэдлийн тухай олон асуудлууд гарсан. Гэрчийг хамгаалах, парламентад мэдүүлэг өгснийхөө улмаас асуудалд орохгүй байх гэх мэтчилэн. Энэ процессууд бол бас нээлттэй сонсгол дээр сүүлийн үед бүрэн хангагдахгүй байгаа. Энийг процесст яаж

хийх хийх вэ? Тэгээд нээлттэй сонсголын журам дээр бас бид нар энийг анхаарах юм нь олон байна. Энийг яах вэ, дараагийн долоо хоногт хэлэлцэх юм байна. Энийг тодруулчихаад, дараа нь нэг юм хэлье.

**Ж.Мөнхбат:** Гурван асуулт асуулаа шүү дээ, тийм ээ. Хэн хариулах вэ? 7 дугаар багш хариулах уу? Мөнхсайхан багш, Бямбадулам хариулъя.

**О.Мөнхсайхан:** Баярлалаа. Тэгэхээр энэ мөрдөн шалгах сонсгол гээд, ер нь бол 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 28.2-т бол Хянан шалгах түр хороог Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь санаачилж байгуулахаар. Энэ хороог байгуулсан тохиолдолд бол гэрчийн мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах, шинжээч томилох гэдэг зэрэг бүрэн эрхийг хашилтад “мөрдөн шалгах” гэх юм уу, энэ тодорхой бүрэн эрхийг өгөхөөр Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолд заасан. Энэний дагуу энэ Хянан шалгах түр хороотой холбоотой, саяын англи хэл дээр тэр мөрдөн шалгах гэж хэлээд байдаг бүрэн эрхүүд бол орчихсон явж байгаа юм. Зүгээр, тэрийг хэн хэрэгжүүлэх вэ гэдэг дээр бол зарчмын зөрүүтэй саналууд гараад, Герман, Австри зэрэг улсуудад бол тэр парламентын цөөнх нь тодорхой тэр эрх мэдлийг хэрэгжүүлж гэсэн санал гаргах юм бол тэрнээс нь олонх нь татгалзвал Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүхээрээ хагалуулчихдаг. Тэгэхээр энэ хувилбар бол энэ удаадаа дэмжигдээгүй учраас одоогоор олонхоороо шийдэхээр явж байгаа. Төсөл бол өргөн барьсан гэдгийг хэлсэн.

Энэ Хянан шалгах түр хороо чинь өөрөө бас тэр нотлох баримтыг сонсголоор шинжлэн судална. Тэгэхээр тэр бол тодорхой төрлийн мөрдөн шаналгах сонсгол мөн үү гэвэл мөн. Бусад сонсголуудыг хувьд бол бас маш олон ийм дэвшилттэй зохицуулалтууд энэ эцсийн хэлэлцэх рүү орж байгаа төсөл байгаа. Тухайлах юм бол бусад сонсголуудыг санаачлах гишүүдийн тоо Нийтийн сонсголын хуулиар 19 байсныг өргөн барьсан төслөөр 5 болгосон. Тэгээд Энхболд гишүүний саналаар 9 болгочхож байгаа юм. Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр ерөнхийдөө 9-өөс доошгүй гишүүн санаачилбал бас сонсгол хийх илүү боломж бүрдэж байгаа юм.

Дээрээс нь Их Хурлын даргын нэгдсэн хуралдаан дээр өгсөн чиглэлийн дагуу бид нар энэ та бүхэнд тарааж өгсөн зарчмын зөрүүтэй саналын есдүгээр хуудсан дээр байгаа Зөрчлийн хууль дээр бол бас парламентыг үл хүндэтгэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтууд орж ирсэн. Өөрөөр хэлэх юм бол чуулганы хуралдаан болон сонсголын үеэр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаан сонсголд оролцсон этгээд дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн зэрэг энэ үйлдэл дээр бол торгох шийтгэл оногдуулах ийм Зөрчлийн хуулийн зохицуулалт бол ороод ирчихсэн байж байгаа. Энэ маань бол өөрөө өмнө нь ийм хариуцлагын механизм байхгүй байсан. Тэгэхээр энэтэй уягдаад ирэхээр бол сая хэлсэн тэр мөрдөн шалгах гэх юм уу, ерөнхийдөө бол тодорхой үр дагавартай энэ бүрэн эрхүүд болж гарч ирж байгаа ийм байдлаар томьёологдсон явж байгаа.

Дараагийн асуултын хувьд томилох, томилгооны зөвшилцөх, танилцах сонсголуудыг хувьд бас Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу томьёоллууд бол орчихсон. Одоо энэ Хянан шалгалтын тухай хуулийн төсөл, Нийтийн сонсголын тухай хуулийн төсөлд яаж задарч орох вэ. Материаллаг зохицуулалт нь бол та бүхэнд тараагдаад өгчихсөн, процессын зохицуулалт нь бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль тусдаа дэд бүлэг үүсгээд тэр их сонсгол явагдах үе шат болгоныг нь бас задалсан. Ийм процедур одоогоор томьёологдсон

байж байгаа. Энийг бас засаж сайжруулаад дараа долоо хоногт дэг орж ирэхэд илүү нарийвчлаад орж ирэх боломжтой гэж бодож байна.

**Ж.Мөнхбат:** Их Хурлын дарга тодруулъя.

**Г.Занданшатар:** Энэ нэгдүгээрт нь, Үндсэн хуулийн 28.2 бол манай гишүүд ч гэсэн аль аль талаасаа болгоомжлоод энэ хуулийг саармагжуулаад байгаа юм. Энэ Хяналт шалгалтын хууль дээр нэг юмыг тодруулж ойлгож авахгүй бол, энийгээ зааж өгөхгүй бол тэр чинь, би Их Хурлын чуулган дээр ч хэлсэн шүү дээ. Үндсэн хуулийн 28.2-т бол нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гэж байгаа юм. Дурын асуудлаар ингээд л Хяналт шалгалтын түр хороо байгуулаад болохгүй. Одоо бүх асуудлаар нээлттэй байгууллага ч гэсэн 19 гишүүн гарын үсэг зураад Хянан шалгалтын түр хороо байгуулсан практик өнгөрсөн 30 жилд бараг байхгүй. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд бол нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар, жишээлбэл Эрдэнэтийн асуудлаар ч юм уу, хөндөөд хяналт шалгалт ийм асуудал гарах юм бол, хүний эрхийн ноцтой зөрчил одоо Зоригийн хэрэг энэ тэр ч гэдэг юм уу. Ингээд нийгмийг хамарсан, нийтийг хамарсан ийм асуудлуудаар л энэ хяналт шалгалтын эрх мэдэл хэрэгжих юм бэ гэдэг ойлголтыг авч явахгүй бол ингээд л ерөөсөө нэг тендер болоод л, хэдэн нийтийн ашиг сонирхол биш хувийн ашиг сонирхлын үүднээс юм уу, аль эсвэл хэсэг.

**Ж.Мөнхбат:** Занданшатар даргад 1 минут нэмж өгье.

**Г.Занданшатар:** Тэрнийгээ бол энэ хуулийн философи, үндсэн зарчимдаа үзэл баримтлалтай, энийгээ гол болгож аваарай. Тэгэхгүй бол ингээд хэдэн гишүүн нийлээд л нэг тендер мендер юу, яагаад ингээд л яагаад байх юм шиг тийм ойлголтыг л явуулж болохгүй. Ийм ойлголт яваад байна.

Хоёр дахь юм нь энэ Элчин сайд нарын томилгооны дэгийг дэгийн хууль өөрчлөхдөө өөрчилж болох уу? Энийг өөрчилчихмөөр байгаа юм. Баахан хүнийг тухайн улстай нь хамт ингээд шүүж байгаа юм шиг ийм процесс явчхаад байдаг. Энийг хэрвээ нээлттэй сонсгол энэ тэр байх бол хаалттай явуулах. Хоёрдугаарт дараалал, зарчим нь өөрөө байгааг Гадаад харилцааны яам олон улсын туршлага судалж байгаад, Ерөнхийлөгч шийдэхээсээ өмнө байдаг юм уу, захирамжаа өгөхөөс өмнө байдаг юм уу, эхлээд нөгөө талаасаа юугаа асуусны дараа ч байдаг юм уу, ингээд олон талын юм харгалзаж байж ингэж Элчин сайдын томилгооны дэгийг томилгооны сонсгол хийхтэйгээ холбогдуулаад энийг бас нэг мөсөн янзалчихмаар юм байна лээ. Сүүлийн үед гарч байгаа практик бол ингээд.

Тэгээд эцсийн дүндээ нэг л юм байгаа юм. Муу хүнд хэчнээн сайхан хууль сайн хууль гараад муу хүн байх юм бол болохгүй. Муу хүмүүст сайн.

**Ж.Мөнхбат:** Их Хурлын дарга тодруулж мэдээлэл, санал хэллээ гэж бодож байна. Саяын Занданшатар даргын хэлж байгааг манай ажлын хэсэг энийг анхаарах хэрэгтэй байх. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар гээд Үндсэн хуулийн бичилт байгаа шүү дээ, тийм үү? Энэ асуудлыг бол 33.1 дээр бол яг энүүгээр нь явах нь зөв байх шүү. Тэгэхгүй бол одоо, Их Хурлын гишүүд төрийн байгууллагын нэг албан тушаалтантай жоохон хувийн харилцааны хувьд таарамжгүй болохоороо л сонсгол хийх гээд давхиад байдаг ийм байдал бол цаашдаа байж болохгүй. Хувь хүний өнцгөөс биш нийтийн ашиг сонирхлын хөндсөн ийм тодорхой асуудлаар. Энэ чинь Үндсэн хууль дээр байгаа бичилт шүү дээ. Тэгэхээр энийг ажлын хэсэг дээр ч юм уу, хасаж ийм санал бас гарч байгаа сураг байсан. Энийг бол хасаж болохгүй шүү. Энэ чинь Үндсэн хуулийн заалт, бичилт шүү.

Тэгэхээр энийг бол цаашид энэ хэвээр нь найруулгыг нь өөрчлөхгүйгээр ингэж авч яваарай гэдгийг хэлье гэж бодож байна.

Ингээд гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураая.

## **НЭГ.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

### **1.1. Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулахчиглэл өгсөнтэй холбоотой саналын томьёолол:**

**Ж.Мөнхбат:** 1.Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Энэ хуулийн 22.2-т заасан дүн шинжилгээ, 22.3-т заасан дүгнэлтийг харгалзан шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал нэг дэх хэлэлцүүлгээс төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл өгч зөвхөн нэг удаа Засгийн газарт буцаана.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Бямбацогт гишүүн асууя. Санал хураалтыг хүчингүй болгоё. Зарчмын зөрүүтэй санал дээр Бямбацогт гишүүн асууна.

**С.Бямбацогт:** Энэ Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан төсөв энэ хуулийн 22.2-т заасан дүн шинжилгээ, 22.3-т заасан дүгнэлтийг харгалзан гэж байгаа юм. Тэгээд энэ хуулийн бол 21, 22 дээр төсвийн хяналт гэсэн төсвийн хяналтын зарчим тусгагдсан байгаа. Тэгээд энүүгээр үндсэндээ бид нар яасан бэ гэхээр, төсвийг өргөн мэдүүлэхдээ Төсвийн хуулийг хэрэгжүүлэхдээ холбогдох бусад хууль Үндсэн хуульд нийцсэн байх ёстой. Нийцээгүй байх юм бол бид нар буцаана, Улсын Их Хурал гэдэг агуулгаар оруулсан юм. Одоо тэгсэн чинь зөвхөн нэг удаа буцаахаар ингэж өөрчилж байгаа юм байна л даа. Зөвхөн нэг удаа.

Монгол Улсын Үндсэн хуульд 25.1.7-д бол Монгол Улсын төрийн бодлогод, Урт хугацааны хөгжлийн бодлогод Монгол Улсын төсөв, үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөр бүгд нийцсэн байх ёстой гээд заачихсан байдаг. Төсвийн тухай хуульд болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тухайн жилийн улсын төсөв нийцсэн байх ёстой. Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд улсын төсөв нийцсэн байх ёстой. Төсөв бол төлөвлөгөөний дагалдах хэсэг нь юм аа. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд төсөв байна. Төлөвлөгөө гэдэг бол бодлого, зорилт. Бодлого, зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай эх үүсвэрийг тооцож байгаа аргачлал нь бол төсөв. Ийм үүднээсээ үндсэндээ бол Монгол Улсын төрийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх төлөвлөгөө, үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд л төсөв санхүүгийн зарцуулах бодлого гарах ёстой.

Гэтэл манай Сангийн яамныхан яадаг вэ гэвэл ерөөсөө төсөв бол хамгийн том юм нь, төсвийн хууль бол хамгийн том юм нь, Их Хурлын гишүүд ч гэсэн төсөв дээр л гол асуудлаа ярих ёстой юм байна гэдэг ойлголтоор явдаг. Тэрнээсээ болоод тэр урт хугацааны хөгжлийн бодлого, дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, богино хугацааны Монгол Улсыг хөгжүүлэх

төлөвлөгөө гэдэг юмыг тоодоггүй, энэ хуулиудтай нийцүүлэхгүй өргөн барьчихдаг. Тэрийг нь бид нар хэлэлцэхгүй бол болохгүй гэдэг үүднээс хэлэлцээд явчихдаг. Эргээд л нөгөө дарга дагасан төсөв, эргээд нөгөө бодлогодоо нийцээгүй төсөв, эргээд саяын ярьж байгаа Богд Зонхова бурхан ч гэдэг юм уу, ийм асуудал болдог.

Энийг л таслан зогсоохын тулд бид нар энэ өргөн барьж байгаа Засгийн газрын төсөв маань бусад хууль тогтоомж, Үндсэн хуульд нийцсэн байх ёстой. Нийцээгүй бол заавал буцааж авах ёстой гэдэг агуулгаар оруулсан. Хэрвээ нэг удаа буцаагаад дахиад л хэвээр өргөн барьчихвал яах юм? Бид нар хэлэлцээд явах уу? Ийм агуулгаар үндсэндээ бол бас ингээд хуулиуд хоорондоо нийцэх ёстой. Төрийн бодлого хэрэгжүүлэхийн тулд бодлого зохицуулалт нь хийгдэж байх ёстой гэдэг агуулгаар л уул нь оруулсан юм. Тэгээд энийг уул нь бас нэлээн анхааралтай авах ёстой байгаа юм шүү. Тэгээд цааш цаашдаа бас сануулга болж, энэ бодлого зарчмаа анхаарах ёстой юм байна шүү гэдгийг бас бид ярих хэлэх ёстой байх.

Хариулт аваад яах вэ дээ, нэг удаа буцаая аа. Гэхдээ Их Хурал дээр бол энэ цааш цаашдаа Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам бол зайлшгүй анхаарах ёстой энэ бодлогын асуудал шүү. Энэ хуульдаа нийцүүлж, төрийн бодлогодоо нийцүүлж улсын төсвийг өргөн барьж байх ёстой. Хэрвээ ингэж өргөн барихгүй бол Улсын Их Хурал буцаах нь байна шүү, цааш цаашаа жоохон хариуцлагатай ажиллах ёстой шүү л гэдгийг бас сануулж хэлье.

**Ж.Мөнхбат:** Бямбацогт гишүүн тайлбар, санал хэллээ. Санал хураалт явуулна.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

12 гишүүнээс 7 гишүүн дэмжиж 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.Төслийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**“29 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол**

29.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонсгол явуулна:

29.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол;

29.1.2.хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол холбогдох Байнгын хороо албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцах сонсгол.

Энэ дээр түрүүн баахан юм ярьсан тийм ээ? Мөнх-Оргил гишүүн тодотгол хийж өгье гэж байгаа шүү дээ, Улсын Их Хурлаас томилогддог гэж. Тэгэхгүй бол энэ чинь хаа хамаагүй бүх л хүмүүс дээр сонсгол хийгээд зөвшилцөөд, танилцах сонсгол хийгээд байх юм болно шүү.

29.2.Нэр дэвшигчийн сонсгол нь баримт, мэдээлэлд үндэслэсэн, талуудын оролцоог тэнцвэртэй хангасан байх бөгөөд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуульд заасан бусад шаардлага хангасан эсэхийг нээлттэй хэлэлцэж, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэнэ.

29.3.Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.

29.4.Нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хууль, Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

29.5.Байнгын хорооноос нэр дэвшигчийн сонсгол /цаашид энэ бүлэгт “сонсгол” гэх/ явуулах үйл ажиллагаанд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

29.6.Нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, тухайн албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлага зэрэг мэдээллийг авах маягтын загварыг холбогдох Байнгын хороо батална.

29.7.Энэ хуулийн 29.6-д заасан загварт дурдсан мэдээллийг нэр дэвшигчээс өөрөөс нь гаргуулна.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12 гишүүнээс 7 гишүүн дэмжиж 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**3.Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“30.2.Сонсголд холбогдох Байнгын хорооны гишүүдээс гадна Нийтийн сонсголын тухай хуулийн 10.2-т заасан оролцогчид оролцох бөгөөд тус хуулийн 15 дугаар зүйлд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12 гишүүнээс 9 дэмжиж 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.



4.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.1.Түр хороо 5-19 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж болно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

**Д.Тогтохсүрэн:** Энэ хугацаан дээр нь яриад байсан, тавиагүй юм уу? Бид нар нэг чуулганы хугацаанд юм уу, хоёр чуулганы хугацаанд юм уу гээд.

**Ж.Мөнхбат:** Нэгэн зэрэг.

**Ж.Сүхбаатар:** Түр хороо хэд ч байгуулагдаж болно шүү дээ.

**Ж.Мөнхбат:** Тийм, 10, 20 ч байгуулагдаж болно. Гэхдээ нэгэн зэрэг гэж байгаа юм.

**Д.Тогтохсүрэн:** Өөрөөр хэлбэл, хоёр чуулганы хугацаанд.

**Ж.Мөнхбат:** Ажлын хэсгийн ахлагч, хугацаа нь тусдаа байгаа биз дээ?

**Д.Тогтохсүрэн:** Тэгэхгүй бол дөрвөн жил Түр хороо нэртэйгээр тэгээд.

**Ж.Мөнхбат:** Хугацаа байгуулаад, тэгээд татан буугдана биз дээ? Тэгэхээр хугацаатай.

Нэг чуулганы бүрэн эрхийн хугацаанд байгуулна. Тэгээд дахиад нэг сунгаж болно. Улсын Их Хурлын хуулиар. Түүгээрээ л явж байгаа.

**Д.Тогтохсүрэн:** /микрофонгүй ярив/

5.Төслийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсгийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12 гишүүнээс 8 гишүүн дэмжиж 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3, 37.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.2.Түр хорооны гишүүн гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл санаачилсан бол тухайн асуудлыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал хураалтаар цөөнх болсон гишүүн тухайн асуудлаар үндэслэлээ дэлгэрэнгүй тайлбарлаж, гурав хүртэл удаа санал хураалгаж болно.”

Тогтохсүрэн гишүүн зарчмын зөрүүтэй санал дээр үг хэлнэ.

**Д.Тогтохсүрэн:** 37.2 дээр уг нь ийм байсан юм. Түр хорооны гишүүн биш юм байхгүй юу. Түр хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй гэж байсан юм. Энийг Түр хорооны гишүүн болгочихсон юм байх юм. Гуравны нэгээс доошгүй нь л санал гаргавал байхгүй юу. Тэгэхгүй бол одоо тэгээд л хэлэлцдэг болчих гээд байгаа байхгүй юу. Хуучин өргөн барьсан хуулийг чинь тийм ээ, Бямбацогт дарга аа? Түр хорооны гишүүдийн гуравны нэг нь санал гаргавал байхгүй юу. Тэгвэл одоо нэг хүн санал гаргахад хураахаар болчихоод байгаа байхгүй юу. Энэ яагаад ингээд дордчихов оо?

Өмнө нь Их Хурлын дарга сая нэгдсэн чуулган дээр чиглэл өгөхдөө зөвхөн Цэцтэй холбоотой асуудлыг шийд гэсэн болохоос биш тэр гуравны нэгийг нь шийд гээгүй байхгүй юу. Тэгсэн чинь гуравны нэг гэдэг заалтыг авч хаяад гишүүн хүн нэг хүн санал гаргахад л явахаар болгоод ингээд санал хураадаг болгоод болгочхож байгаа байхгүй юу. Тийм учраас би бол юу гэж байна гэхээр энэ дээр тэр яг анхны төслөөр нь Түр хорооны гишүүдийн гуравны нэг нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах санал гаргасан бол түүнийг Түр хорооны гишүүд олонхоороо шийднэ гэдэг энэ саналаараа л баймаар байна. Би тийм санал гаргаад байгаа юм. Тийм санал хэлье.

**Ж.Мөнхбат:** Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар гишүүн хариулъя.

**Ж.Сүхбаатар:** Тогтохсүрэн гишүүний хэлж байгааг тэгээд юу яагаад явчихъя даа. Би ер нь бол энэ хуулийн төслийг гаргахын тулд Энхболд гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Тогтохсүрэн дарга гурвын санал ер нь энэ нийт саналын чинь бараг 80 хувь эзэлж байгаа шүү дээ. Нэгэнт Тогтохсүрэн дарга бас энийг байн байн ярьж байгаа. Тэгээд энийг нь оруулаад л саяынхаар, нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэдгээр л явчихъя гэж бодож байна.

**Ж.Мөнхбат:** Мөнхсайхан /гишүүн/ тайлбар хэлээдэхье. 7 дугаар микрофон.

**О.Мөнхсайхан:** Тэгэхээр энэ бол энэ Хянан шалгах түр хорооны ерөөсөө амин сүнс л байгаа л даа. Яг энэ дээр би одоо судалгаа хийсэн хүний хувьд, бусад улсуудын жишиг хоёр л хувилбар байгаа юм. Хянан шалгах түр хороог нийт парламентын гишүүдийн дөрөвний нэгээс доош хүй нь байгуулж байгаа бол тэр Түр хорооны гишүүдийн дөрөвний нэгээс доош нь нотлох баримт цуглуулах эрхийг нь шууд өгч байгаа юм. Хэрвээ энийг авахгүй тохиолдолд тэр Герман, Австрид байдаг шиг цөөнхийн авъя гэж байгаа нотлох баримтыг авахгүй байгаа нь үндэслэлтэй эсэхийг нь Үндсэн хуулийн шүүх юм уу, Дээд шүүхээрээ хянуулдаг.

Энэ бол судлаач хүний хувьд бол хамгийн сайн хувилбар гэж харж байгаа юм. Тэгээд энэ хоёр хувилбарыг хоёуланг нь авахгүй гэж үзэх юм бол одоо яаж байна вэ гэхээр хуралдаанд сууж байгаа гишүүд олонхоороо шийднэ гэдэг маш өндөр босго тавьчихаж байгаа. Ерөнхийдөө тэр Түр хорооны гишүүдийн олонх бол ямар нотлох баримт авах вэ гэдгийг шийдсэн ийм өндөр босго гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг сөхөх, гаргаж тавих, санаачлах босгыг бол гуравны нэг юм уу дөрөвний нэг гэж өндөрсгөх юм бол энэ бол бүр ингээд ажиллахгүй болох гээд байгаа байхгүй юу.

Тэр гуравны нэг, дөрөвний нэг гэдэг тоо бол анх яаж гарч ирсэн бэ гэхээр шууд нотлох баримтыг өөрсдөө тэр дөрөвний нэг өөрөө цуглуулах, эсвэл гуравны нэг нь санал гаргаад тэрийг нь олонхоор нь хүлээж авахгүй бол Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаад цэцээр хагалуулдаг ийм хувилбар дээр л тэр санаачилга, босго яригдаж байсан. Хэрвээ санаачилга дээр ахиад гуравны нэг гээд тавьчих юм бол энэ маань өөрөө ер нь маш их хэцүү л ийм л процедур луу орно л гэж харж байгаа. Тэгэхээр нэг гишүүн санаачлаад угаасаа олонхоороо шийдэх учраас энэ дээр бол хуралдаанд сууж байгаа гишүүдийн олонхоороо шийдье гэсэн санал бол зарчмаар тусгагдчихсан өндөр босготой болчхож байгаа учраас нэг гишүүн энэ санал гаргах, төсөл санаачлах нөгөө ердийнхөө тэр Түр хорооны гишүүнийхээ бусад Түр хороон дээр байдаг гишүүдийн эрхтэй адилхан эрхээрээ байвал яасан юм бэ гэсэн энэ томьёоллыг бол ажлын дэд хэсгийн гишүүний хувьд дэмжиж байгаа.

**Ж.Мөнхбат:** Энэ ийм шүү, энэ саналыг хэрвээ унавал нөгөө Цэц рүү очно гэдэг юм чинь. Одоо ийм байна. Ажлын хэсгийн анх оруулсан 37.2, та бүхэн сонсоорой. Ажлын хэсгийн ийм санал байна. Түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл санаачилсан бол тухайн асуудлыг Түр хорооны гишүүдийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал хураалтаар цөөнх болсон гишүүн тухайн асуудлаар үндэслэлээ дэлгэрэнгүй тайлбарлаж, гурав хүртэл удаа санал хураалгаж болно гэж байна. Хуралдаанд орсон гишүүдийн шүү. Түр хорооны нийт гишүүдийн биш. Ийм зарчмын санал байна. Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Тэгэхээр ийм байгаа юм аа. Яах вэ, би саяын хэлж байгаа саналаа больё. Гэхдээ Сүхбаатар аа, нэг юм хэлье. Энэ ингэж болохгүй шүү. Их Хурлын дарга энэ дээр гуравны нэг дээр огт чиглэл өгөөгүй байх байхгүй юу. Гэтэл дураараа хасаж байгаа байхгүй юу, та нар. Гурван нэг дээр чиглэл өгөөгүй. Юун дээр чиглэл өгсөн бэ гэхээр Цэц рүү явдгийг нь болиул аа, Их Хурал өөр дээрээ шийддэг болго гэсэн л болохоос биш, гурван нэг юм болиулья гээгүй байхгүй юу. Гэтэл гурав нэг нь болиулчихаж байгаа байхгүй юу, бүр дураараа. Тэгээд яах вэ, би энэ санал уначихгүйн тулд дэмжье. Өөр санал гаргахаа болилоо, түрүүний саналаа татлаа. Гэхдээ ийм заваан юм хийдгээ болино шүү. Энэ чинь юу гэсэн үг юм Мөнхсайхан, чи хууль бичдэг байж болно. Гэхдээ ингэж болохгүй шүү. Ингэж гишүүдийн эрхэд халдаж болохгүй шүү. Ингээд даварч болохгүй шүү, ер нь хатуухан хэлэхэд.

Ингэж болохгүй. Гуравны нэг гэдэг тоо анхнаасаа хууль санаачлагчид өргөн барьсан тоо. Анхны хэлэлцүүлгээр энүүгээрээ явсан тоо. Эцсийн хэлэлцүүл дээр юу гэж чиглэл өгсөн бэ гэхээр ганцхан Үндсэн хуулийн цэц рүү явдаг заалтыг л хэлсэн байхгүй юу. Гэтэл өөр заалтаар хусаад хаячхаж байгаа байхгүй юу. Энэ бол яаж ч болно, ажлын хэсэг гэж, тэр дундаа дэд ажлын хэсэг ингэж бүдүүлэг хандахгүй шүү цаашдаа энэ хууль дээр. Энэ бол дэгийн хуулийг ноцтой зөрчихөж байгаа юм шүү, юм яривал. Тийм учраас би бол энэ хуулийн энэ заалтыг дэмжиж байгаа учраас энүүгээр нь явуулчихъя. Ер нь цаашдаа ийм юмыг гаргахгүй байхыг харин хүсье гэж бодож байна.

**Ж.Мөнхбат:** Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар гишүүнээс асууя. Түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай гээд танай ажлын хэсэг дээр орсон анхны саналаар нь санал хурал очих уу? Тэгээд ялгаагүй, энэ зарчмын зөрүүтэй санал чинь хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн бол гээд тэгж байна шүү дээ. Ялгаагүй л юм байна шүү дээ. Зарчим нь бол нэг үү, гуравны нэг үү гэдэг л асуудал байна шүү дээ, энэ дээр. Тийм, зарчмын асуудал байхгүй юу.

**Ж.Сүхбаатар:** /микрофонгүй ярив/ ... гуравны нэгээрээ үлдсэн. Төсөл дээрээ дөрөвний нэг гэж байсан юм.

**Ж.Мөнхбат:** Тийм, дөрөвний нэг гэж энэ байна.

**Ж.Сүхбаатар:** Тэгэхээр цаад талд нь юу үүсэх вэ гэхээр... тэр нь байхгүй болчихсон учраас тэр гуравны нэг чинь бүр хийхгүй явсан нь дээр. /микрофонгүй ярив/

**Ж.Мөнхбат:** Тэгвэл Тогтохсүрэн гишүүн саналаа татсан учраас энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор ажлын хэсгийн оруулж ирсэн санал хураах боллоо шүү, манайхан. 37.2 дээр. Би дахиад уншъя.

37.2.Түр хорооны гишүүн гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл санаачилсан бол тухайн асуудлыг Түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

Санал хураалтаар цөөнх болсон гишүүн тухайн асуудлаар үндэслэлээ дэлгэрэнгүй тайлбарлаж гурав хүртэл удаа санал хураалгаж болно. Бямбадулам зөвлөх, 6 дугаар микрофон.

**Ж.Бямбадулам:** Энэ, Түр хорооны гэрчээр дуудах, нотлох баримт цуглуулах санал гаргах нь өргөн барьсан төсөл дээр босго тогтоодог нь болохоороо цөөнхөөс санал гараад босго тогтоосны гол онцлог нь санал гарсан л бол тогтоол батлагдсанд тооцох өргөн барьсан төслийнх тийм зохицуулалттай байгаа юм. Тэгэхээр тогтоол бол цөөнхөөс шууд санал гарсан тохиолдолд батлагдсанд тооцогдохгүй, олонхоороо шийдэж байгаа учраас босгыг нь бууруулсан. Хэрвээ энэ санал дэмжигдэхгүй байх юм бол цөөнхийн гаргасан санал батлагдсан ч шууд тогтоол батлагдсанд тооцогдох зохицуулалтаараа үлдэнэ.

**Ж.Мөнхбат:** Занданшатар дарга үг хэлэх үү?

**Г.Занданшатар:** Нэгдсэн хуралдаан дээр өгсөн чиглэл бол нэгдүгээрт, Үндсэн хуулийн цэц дээр хэрэг маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хууль, тогтоол, Цэцийн маргаан хянан шийдвэрлэх хуулийн асуудал болохоос биш зарчмын зөрүүтэй санал Цэц дээр очдог тийм Цэцийн тогтоол болохгүй юм аа. Тэр тусмаа Түр хороон дээр мөн Байнгын хороон дээр гаргасан саналыг Цэц дээр аваачаад өгөөд ингээд санал хураалт хянагддаг ийм. Тэгээд тэрийг аль тэр хугацаанд үргэлжлэх юм, хэдэн жилд болгох юм, Цэцийн процесс байхгүй. Тэгвэл Цэцийн процессын хуулийг шинээр бичих хэрэгтэй болно.

Тийм учраас Цэцийн тухай заалтыг нь хасаад, тэгээд хяналт шалгалтынхаа Үндсэн хуулийн үндсэн зарчимд нийцүүлээд гүйцээн боловсруулах чиглэлээр санал хураагдаагүй байхгүй юу. Санал хураахгүйгээр ингээд явчихсан. Энэ тохиолдолд босоо санал босоогоор үлддэг байхгүй юу. Өмнөх босоо санал нь. Тийм учраас энэ саналаа дэмжиж байж болохгүй бол дөрөвний нэг гэдэг хуучин санал чинь босож байгаа байхгүй юу.

**Ж.Мөнхбат:** Тийм, Санал хураая. Түрүүн би уншихсан шүү. 37.2. Санал гаргасан ажлын хэсэг.

Ажлын хэсгийн оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж байна. Санал хураалт унах юм бол дөрөвний нэг, шууд тогтоол батлагддаг юм босно шүү.

Санал хураалт

12-11 дэмжиж, 91.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхээр Мөнхсайхан багш аа, Түр хорооны нэг гишүүн ч гэсэн санал гаргах эрхтэй боллоо шүү.

**7.Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.5 дахь хэсэг нэмэх:**

“17.5.Улсын Их Хурал энэ хуулийн 17.4-т заасан тогтоол баталсан бол тухайн тогтоолд заасан хугацаанд Засгийн газар тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

2-9 дэмжиж, 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**8.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.7 дахь хэсэг нэмэх:**

“19.7.Улсын Их Хурал энэ хуулийн 19.2, 19.6-д заасан тайланг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-11 дэмжиж, 91.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**1.2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу гуравны хоёроор дэмжих саналын томьёолол:**

Гуравны хоёроор дэмжих саналууд шүү. Ажлын хэсгээс горим гаргах уу? Гуравны хоёроор хураалгая гэдэг. Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Энэ төсөл та бүхэнд танилцуулж байгаа 9, 10, 11 дүгээр санал дээр гуравны хоёроор дэмжүүлэх саналыг бэлтгэсэн байгаа. Энийг хураалгаж өгөөч ээ.

**Ж.Мөнхбат:** Ажлын хэсгээс гаргасан горимын саналаар гуравны хоёроор дэмжигдэх санал хураалгая гэж байна. 9, 10, 11 дээр.

Горимын саналаар санал хураая. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт  
12-11 дэмжиж, 91.7 хувиар санал дэмжигдсэн. Дэмжигдсэн тул,

**9.Төслийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийг хасаж, дугаарыг өөрчлөх.**

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт. Гуравны хоёроор дэмжигдэнэ шүү.

12-11 дэмжиж, 91.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ж.Сүхбаатар:** Сая бүгдийг нь хэлчихсэн шүү дээ. Би уул нь 9, 10, 11 гэсэн шүү дээ.

**Ж.Мөнхбат:** Ажлын хэсгийн дарга санал гаргая. Уг нь би түрүүлээд 9, 10, 11 гээд хэлчихсэн юм. Тэгээд дэгээр бол бас зовлонтой л юм байна л даа.

**Ж.Сүхбаатар:** Төслийн 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсгийг хасах энэ 10 дугаар саналыг бас гуравны хоёроор дэмжих санал оруулж байна.

**Ж.Мөнхбат:** Ажлын хэсгийн ахлагчийн гаргасан горимын саналаар санал хураая.

Санал хураалт. Гуравны хоёроор дэмжигдэнэ шүү.

12-11 дэмжиж, 91.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**10.Төслийн 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсгийг хасах.**

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-10 дэмжиж, 83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагч горимын санал гаргах уу? Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг хасах 11 дүгээр саналыг гуравны хоёроор дэмжүүлэх саналыг оруулж байна.

**Ж.Мөнхбат:** Ажлын хэсгийн ахлагчийн гаргасан горимын саналаар санал хураая.

Санал хураалт

12-11 дэмжиж, 91.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**11.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг хасах.**

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-11 дэмжиж, 91.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Тайлбар:** Зарчмын зөрүүтэй 11 дэх санал дэмжигдсэн тохиолдолд дараах саналаар санал хураана:

1.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх.

2.Хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-8 дэмжиж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

### **1.3.Зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбоотой найруулгын санал:**

1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.5, 19 дүгээр зүйлийн 19.5, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “Төрийн аудитын” гэсний өмнө “Улсын Их Хурлын Тамгын газар болон” гэж, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “сонсголын тухай” гэсний дараа “болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хэсэг, түр хорооны” гэснийг “хэсгийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах” гэснийг “энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтын “хэлэлцүүлгийн шатны” гэснийг “хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны” гэж, 23 дугаар зүйлийн гарчгийн “Төсвийн төслийн” гэснийг “Хоёр дахь” гэж, мөн зүйлийн 23.1, 23.4 дэх хэсгийн “Төсвийн төслийн” гэснийг “Хоёр дахь” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “явуулна” гэснийг “явуулж болно” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалтын “дүгнэлт, шаардлагатай бол тогтоолын төсөл боловсруулж” гэснийг “дүгнэлтээ” гэж, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “Цахим нотлох баримтыг бичмэл нотлох баримтад тооцно.” гэснийг “Бичмэл нотлох баримт нь цахим хэлбэртэй байж болно.” гэж, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “томилно. Хянан шалгагч томилох тухай түр хорооны тогтоолд хянан шалгагчийн ажлын даалгавар, шаардлагатай бол ажиллах хугацааг тогтооно.” гэснийг “томилж, ажлын даалгаврыг батална.” гэж, мөн зүйлийн 44.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 44.3.2-т заасны дагуу нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол хянан шалгагч энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтыг цуглуулах тухай тогтоол гаргуулах саналаа түр хороонд гаргана.” гэснийг “Хяналт шалгалтын явцад нотлох баримт гаргуулах шаардлагатай гэж үзвэл хянан шалгагч энэ хуулийн 37.1-д заасны дагуу тогтоол гаргуулах саналаа түр хороонд оруулна.” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “Хянан шалгах түр хорооны сонсголд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь саналаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хуралдааны явцад дуу, эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.” гэснийг “Энэ хуулийн 46.2-т заасан оролцогчид

сонсголын явцад дуу, эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх.

**3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“5.1.Улсын Их Хурал хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/-тай байна.

5.2.Мэдээллийн нэгдсэн сан нь Улсын Их Хурлаас явуулсан хяналт шалгалтын холбогдох баримт бичиг, мэдээлэл болон хяналт шалгалтын бусад байгууллагаас гаргуулж авсан мэдээлэл, хууль тогтоомжид заасан бусад тогтмол мэдээллээс бүрдэх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн нэгдсэн сан олон нийтэд нээлттэй байна.”

“30.1.Байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсгол даргалагчийг сонгох бөгөөд сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална. Сонсгол даргалагч Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

**4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.3, 25.4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.3, 28.2.4 дахь заалтын “, түр” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн “, түр хорооны гишүүнийг томилох санал” гэснийг тус тус хасах.**

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт. Найруулгын саналууд явж байна.

12-9 дэмжиж, 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, төслийн 33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсгийн Хянан шалгах түр хорооноос шүүх болон эрх бүхий бусад байгууллагын хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавар өгөхийг хориглоно гэснийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулахгүй бөгөөд Хянан шалгах түр хорооноос шүүх болон эрх бүхий бусад байгууллагын хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох заавар өгөхийг хориглоно гэж өөрчилнө гэж санал гаргасан байна.

Мөнх-Оргил гишүүн саналаа тайлбарлая.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ, Энхболд гишүүн бид хоёр ажлын хэсэг дээр хоёр ч удаа санал хураалгаад дэмжлэг аваагүй юм. Тэгээд энэ дэмжлэг аваагүй үндэслэл нь болохлоор Хянан шалгах түр хороо байгуулаад л Улсын Их Хурал хянан шалгах эрх мэдлээ хэрэгжүүлье гэхээр л энэ асуудал эрүүгийн хэрэг үүсгэчихсэн хянан шалгаж байгаа гээд л бүх юмыг нь хаачихна гээд байгаа юм. Тэгээд Энхболд гишүүн бид хоёрын санал болохоор энийг жоохон ялгаатай авч үзэхгүй бол яг шүүх дээр байж байгаа асуудал. Жишээ нь Эрдэнэтийн асуудал гэхэд л нийтийн эрх ашгийн үндэслэл асуудал мөртөө дотроо тэр чинь дахиад задраад, шүүх дээр хэд хэдэн асуудал болчихоод явж байгаа шүү дээ. Ингэж ялгаж салгах бололцоотой байгаа байхгүй юу.



Тэгээд яг шүүх дээр байж байгаа, эсвэл яг эрүүгийн хэрэг үүсээд мөрдөн шалгаж байгаа юмнуудыг бол Улсын Их Хурал авч хянан шалгах үйл ажиллагаа явуулмааргүй л байгаа байхгүй юу. Энийг нэг салгахгүй бол, одоо яг энүүгээрээ баталчих юм бол зүгээр л Хянан шалгах түр хороо нь угаасаа хуулиараа хориотой, шүүх, прокурор дээр байгаа аливаа асуудалд хөндлөнгөөс оролцохгүй, шүүх прокурор дарамт үзүүлэхгүй гэсэн заалт нь л давтагдчих гээд байгаа байхгүй юу. Угаасаа тэр чинь хуулиараа байж л байгаа шүү дээ, бид нар чинь Үндсэн хуулиараа ч, Улсын Их Хурлын хуулиараа ч гэсэн шүүх, прокурорын ажилд хөндлөнгөөс оролцох эрхгүй шүү дээ. Энийг нэг яаж шийдэх ёстой байгаа юм. Ер нь бол санааг нь би ойлгоод байгаа юм. Аливаа асуудлыг гараад ирэхээр нь энэ чинь хэрэг үүсгэчихсэн, шүүх дээр байгаа гээд хаачаад байх нэг аюул байгаа, тийм ээ?

Гэтэл нөгөө талаасаа яг шүүх дээр асуудал нь шийдэгдэж байгаа юм руу Улсын Их Хурал хянан шалгах үйл ажиллагаа оруулаад л, гэрч дуудаад л, дүгнэлт гаргаад л, протокол оруулаад л, тогтоол батлаад байхад чинь өөрөө шүүх, прокурорын ажилд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого болоод явчихна шүү дээ. Энийг салгах хэрэгтэй байна.

**Ц.Мөнх-Оргил:** Мөнхсайхан багш тайлбар хэлье гэж санал ирүүлсэн байгаа. Мөнх-Оргил гишүүний энэ гаргасан санал ажлын хэсэг дээр эхний болон эцсийн хэлэлцүүлэг дээр хоёр удаа санал гаргаад хоёулаа унасан дэмжигдээгүй, унасан санал байгаа. Тийм учраас Мөнхсайхан багш тайлбар хэлье.

**О.Мөнхсайхан:** Баярлалаа. Энэ маш чухал ийм асуудал энэ дээр хөндөгдөөд байгаа юм. Тэгээд энэ төсөл боловсруулж байх үед бас дараа нь бол маш олон удаа яригдсан. Өөрөөр хэлбэл энэ чинь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа тохиолдолд тухайн асуудалтай холбоотой нийтийн эрх ашгийг хөндсөн зүйлээр Хянан шалгах түр хороо байгуулж болох уу, үгүй юу л гэдэг ийм юм байгаа юм. Энэ маань өөрөө энэний цаана хууль тогтоох эрх мэдлийн хяналт шалгалтын бүрэн эрх, нөгөө талаасаа шүүх эрх мэдэл хоёрын балансыг яаж олох вэ л гэдэг маш хэцүү ийм асуулт байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр гишүүд маань аль нэг тал руу нь шийдэх байх. Зүгээр харьцуулсан судалгаа бас яг энэ дээр хийгдсэн юм. Санаачилсан ажлын хэсгийн ахлагчийн өгсөн даалгаврын дагуу.

Тэгээд ингээд үзэхээр Венецийн комисс, Европын холбоо бас яг ийм түр хороо ажилладаг Австри, Герман зэрэг улс, пост коммунист Эстони, Латви бүх улсынх нь энэ хуулийг харьцуулаад харсан. Ингээд харахад яг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа гэдгээр шууд ингээд бүхэлд нь хориглосон зохицуулалт бол олдоогүй. Венецийн комиссын энэ тайлбар энэ нөгөө та бүхэнд тарааж өгсөн нөгөө номын 144 дүгээр хуудас дээр байж байгаа юм. Өөрөөр хэлбэл, тодорхой асуудал үүслээ гэхэд энд бол эрүүгийн болон бусад хянан шийдвэрлэх ажиллагаа өөр өөрийнхөө чиг үүргээр явагдана. Тэр нь өөрөө гэм бурууг тогтоох, хариуцлага тооцох чиг үүрэг байж байгаа.

Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо тухайн асуудлаар зэрэгцэж байгуулагдаж болох боловч яг манай төслийн энэ 33.10-т орчихсон байгаа шигээр тэр хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавал өгөхийг нь хориглоно. Жишээ нь шийтгэл оногдуулах, гэм бурууг тогтоох иймэрхүү асуудал руу ерөөсөө орохгүй. Тусдаа нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаараа баримтууд цуглуулаад дүгнэлт гаргаад олон нийтэд тэр мэдэх эрхийг нь хангана гэдэг энэ зарчим үйлчилнэ гэдгийг хэлсэн байж байна. Энэ хоёр процедур нь бол зэрэгцээд явдаг. Жишээлбэл Германд яг одоо бол гурван түр хороо ажиллаж байгаа байхгүй юу. Нэг нь тэр террорист халдлага болсон байгаа юм. Тэр

террорист халдлагатай холбоотой асуудлаар түр хороо ажиллаж байгаа юм. Энэ дээр бол мэдээж эрүүгийн хэрэг бол үүсчихсэн юугаараа шалгагдаж байгаа. Гэхдээ ерөнхийдөө тэр террорист халдлага яагаад гарав, урьдчилан сэргийлэх боломжтой байсан уу, холбогдох албан тушаалтнууд хийх ажлаа хийсэн үү, цаашдаа ийм юм гарахаас урьдчилан яаж сэргийлэх вэ гэдэг тэр зүйлээрээ бол ингээд бас дүгнэлт гаргаад явж байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ дээр бас арван жилийн өмнө Чимэд багш яг энэ сэдвээр бичсэн өгүүлэл, судалгааг бас бид нар үзсэн юм. Тэгэхэд бол тэр Марз онгоцны ослын жишээг авч энэ дээр ингээд цуурхал яваад байдаг. Тэгсэн мөртөө иргэд тэрийг угаасаа хэлэлцэж байгаа учраас жишээлбэл ийм Хянан шалгах түр хороо байгуулагдаад, бодитой дүгнэлт гаргах ийм юу дутаж байна гэдэг ийм санаа бол жишээ авсан байсан л даа. Тэгэхээр тэр чинь бол, тэр хэрэг дээр чинь бас эрүүгийн янз бүрийн хэрэг бол үүсэж таарч байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яг энэ балансыг нь олно гэдэг бол хэцүү учраас, ингээд энэ бүхэн дээр үндэслээд өргөн барихын өмнө ч ярьсан, дараа нь ингээд яахаар, энэ төсөлд байж байгаа 33.10 нь ямар ч байсан зааг ялгааг нь гаргасан ийм нэг хувилбар юм болов уу л гэсэн байдлаар орчихсон явж байгаа.

Дээрээс нь төслийн 4.2.3 дээр энэ Улсын Их Хурал хянан шалгалтаа хэрэгжүүлэхдээ гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй гэдэг бас зарчим байж байгаа. Тэгэхээр энүүгээр бол шүүх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдлийнхээ харьяаллын асуудлыг хүндэтгэж ингээд хандах ийм боломжтой юм болов уу л гэсэн ийм бодол байгаа. Баярлалаа.

**Ж.Мөнхбат:** Сүхбаатар гишүүн нэмж тайлбар хэлье.

**Ж.Сүхбаатар:** Энэ ингээд арай дутуу байна л гээд үзээд байх шиг байгаа юм, Мөнх-Оргил гишүүн бол. Яг Мөнх-Оргил гишүүн, Энхболд гишүүн хоёрын саналаар бол ингээд ерөөсөө бүхэлд нь хаачхаж байгаа байхгүй юу наадах чинь. Гол агуулга нь бол би ойлгоод байгаа юм. Энэ хоёр маань юу хэлээд байна вэ гэхээр Оросууд ч гэсэн, тэгээд бусад улс орнууд гээд хэлээд байгаа юм нь, сая Мөнхсайхан арай бүдэг хэлчихлээ. Энэ бол шүүн таслах үйл ажиллагаа, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа, энэ бол парламентын тусгай шалгалт буюу бид нар мөрдөн шалгалт гэж яриад байгаа тийм ээ. Энэний объект бол биш. Нөхцөл байдлыг тодруулах, фактыг шинжлэн судлах энэ агуулгаар байж байгаа. Тэгэхээр энэ бол гол юм нь шүүн таслах үйл ажиллагаа, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа бол энд хамаарахгүй. Энэ агуулгыг нь сая хэллээ. Түр орлон гүйцэтгэхгүй гэж байна шүү дээ. Энэ парламентын мөрдөн шалгалтын үйл ажиллагаа бол энэ эрүүгийн байцаагчдын үйл ажиллагааг орлуулж байгаа ийм хэлбэр бол биш. Тэгэхдээ тэнд байгаа асуудлуудыг факт нөхцөл байдлуудыг тодруулж үзнэ гэдэг.

Яг энэ асуудлаар чинь бусад улс оронд яагаад байхгүй байна гэхээр энэ асуудлыг хийчихээр, тэр үйл ажиллагаан дээр байгаа олон асуудлуудыг энэ парламентын мөрдөн шалгалт угаасаа аль ч улс оронд яригдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бүхэлд нь бүр хаана гэхээр энэ хуулийн утга, ач холбогдлыг эрс сулруулах аюултай учраас л бид нар энэ асуудлыг яриад байгаа байхгүй юу. Тэгээд дээр нь Улсын Их Хурал чинь өөрөө энэ түр хороог байгуулах явцдаа тэрний хүрээ, хязгаар сэдэв, бүх юмыг чинь тал талаасаа ярилцана. Одоо тэгээд ирэхээр л тэр үед нь гишүүд энэ чинь хууль зөрчих гээд байгаа юм биш үү, Хууль зүйн байнгын хороо бас ийм юм болжээ гэдэг ч юм уу. Ингээд хүрээ заагаад хууль зөрчихгүйгээр тухайн үед нь Улсын Их Хурал өөрөө авч үзээд явах байхгүй юу.

Тэрэн дээр бид нар алдаа гарвал энэ үйл ажиллагааг нь бас холбогдох улсууд дээр цаана нь энийг засаж залруулахын тулд бусад тэр газраа хандах хэрэгтэй шүү дээ. Цэц дээр ч байна уу, дараа нь тогтоол гараад ирэхээр түр хороо байгуулчихвал ч гэдэг юм уу механизм байгаа юм. Тэгэхээр ингэж хаалга бүрэн хааж болохгүй л гэж байгаа юм. Тэгэхээр энийг шууд хаачих гээд байгаа байхгүй юу. Одоо Мөнх-Оргил гишүүн, Энхболд гишүүн хоёрын саналаар орсон ийм асуудал орох юм бол жишээлбэл Зоригийн хэргийнх шиг асуудлыг бол шууд хаачхаж байгаа байхгүй юу. Тэр түр хороо байгуулж байгаа чинь боломжгүй байхгүй юу.

Амьдрал дээр асуудал гарч ирнэ шүү дээ. Яагаад вэ гэхээр энэ судалгааны материалд байж байгаа зарим арав, хорин жил үргэлжилж байгаа ийм хэргүүд байдаг юм байна. Шүүхийн, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд шийдэгддэггүй. Гэтэл энийг бусад улс оронд татаж авчраад парламент дээрээ ярсны хүчинд, шахах шаардсаны хүчинд харин тэр үйл ажиллагаа илрээд шийдэгдсэн байгаад байгаа байхгүй юу.

**Ж.Мөнхбат:** 1 минут нэмж өгье, Мөнх-Оргил гишүүнд.

**Ц.Мөнх-Оргил:** Гишүүдээ энэ асуудалд их анхаарлаа хандуулаарай. Магадгүй энэ заалтаас болоод манай энэ хянан шалгах үйл ажиллагаа чинь шал өөр замаар явчих аюул гарна шүү. Магадгүй Энхболд бид хоёрын томьёолол дэндүү өргөн байж магадгүй. Тэгэхдээ ямар ч байсан гэсэн зааг нь нэг гаргаж салгаж өгөх хэрэгтэй байгаа юм. Манайд энэ чинь шинэ юм шүү дээ. Бид нар ингэж бодоод, нэгийг бодоод л биччихдэг, бидний өнөөдрийн байж байгаа байдал, улс төрийн соёл, энэ намуудын, улс төрчдийн төлөвшил хэрэгжилтийг шал өөр тийшээ л аваад явчихна шүү дээ. Тийм учраас хаа нэгэн газар нь.

Санаснаар юм бүтэхгүй шүү дээ. Санаснаас муугаар л болно гэж тооцож бид нар хаа нэгэн газар хязгаар хүрээг нь тогтоож авахгүй бол болохгүй байхгүй юу. Жишээ нь сая тэр Чимид багшийн жишээ болгож байсан Марз уулын ослын асуудлыг ярья гэж бодъё л доо. Тэгтэл магадгүй энэ томьёоллоор бол бүгдийг нь хаачихаж магадгүй. Тэгэхээр нь жоохон заагийг нь гаргаад өгчихье.

**Ж.Мөнхбат:** Энэ саналаар санал хураах уу, үгүй юу гэдгийг гуравны хоёроор санал хурааж шийднэ. Тийм учраас Мөнх-Оргил гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураах уу, үгүй юу гэдгээр санал хураалт явуулъя. Гуравны хоёроор явуулъя гэж дэмжих юм бол санал хураалт явагдана гэсэн үг.

Санал хураалт

12-4 дэмжигдэж, 33.3 хувийн саналаар Мөнх-Оргил гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгах боломжгүй болж байна. Цаашаа явъя. Өөрөө дэмжиж санал өгсөн байна, Мөнх-Оргил гишүүн.

## **ХОЁР.ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

### **2.1.Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөнтэй холбоотой саналын томьёолол:**

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт буюу 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг нэмэх:

**2/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг:**

“12.4.Нэр дэвшигчийн сонголд оролцогч гэж энэ хуулийн 10.2-т заасан оролцогчдыг ойлгоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 23<sup>1</sup> дүгээр зүйл нэмэх:

**3/23<sup>1</sup> дүгээр зүйл.Сонсголын зардал**

**“23<sup>1</sup> дүгээр зүйл.Сонсголын зардал**

23<sup>1</sup>.1.Сонсгол зохион байгуулахтай холбогдон гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. ”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, төслийн дугаар өөрчлөх:

**“3 дугаар зүйл.**Нийтийн сонсголын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйл.Үндсэн болон тусгай зарчим:**

**“3 дугаар зүйл.Үндсэн болон тусгай зарчим**

3.1.Нийтийн сонсголыг зохион байгуулахад ардчилсан ёс, хууль дээдлэх, баримт, мэдээлэлд үндэслэсэн байх, талуудын оролцоог тэгш хангах, иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, үр нөлөөтэй байх үндсэн зарчмыг удирдлага болгоно.

3.2.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахад дараах тусгай зарчмыг баримтална:

3.2.1.нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандах;

3.2.2.нэр дэвшигч, оролцогчдод хүндэтгэлтэй хандах;

3.2.3.ил тод, нээлттэй байх.

3.3.Энэ хуулийн 3.2-т заасан тусгай зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно:

3.3.1.“нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандах” гэж нэр дэвшигчийн албан тушаалын болон бусад байдлаас үл хамааран асуултад хариулах, санал хэлэх боломжийг бүх нэр дэвшигчид тэгш олгох бөгөөд аль нэг нэр дэвшигчид давуу байдал олгохгүй байхыг;

3.3.2.“нэр дэвшигч, оролцогчдод хүндэтгэлтэй хандах” гэж албан тушаалын болон бусад байдлаас үл хамааран нэр дэвшигч, оролцогчоос асуулт асуух, үг хэлэхдээ хүндэтгэлтэй хандахыг;

3.3.3.“ил тод, нээлттэй байх” гэж нэр дэвшигчийн сонсголд оролцох хүсэлт гаргасан бол хуулийн үндэслэлгүйгээр татгалзахгүй байх, сонсголыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд, бүрэн дамжуулах, сонсголын тэмдэглэл ил тод байх, оролцогчид тэмдэглэлтэй танилцаж өөрийн саналыг хянах боломжтой байхыг.”

## **2/10 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол:**

### **“10 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол**

10.1.Энэ хуулийн 6.2.4, 6.2.7, 6.2.8-д заасан сонсголыг нэр дэвшигчийн сонсгол гэх бөгөөд тэдгээрийг зохион байгуулж, явуулахдаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай болон холбогдох бусад хуулийг баримтална.

10.2.Нэр дэвшигчийн сонсголд нэр дэвшигч, түүнийг Улсын Их Хуралд танилцуулах эрх бүхий этгээд, эсхүл түүний төлөөлөгч, нэр дэвшигчээс асуулт асуух, нэр дэвшигч нь тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсэх талаар санал хэлэх, мэдээлэл өгөхөөр хүсэлт гаргасан болон хуульд заасны дагуу мэдээлэл өгөх иргэн, хуулийн этгээд, ажиглагч оролцоно.

10.3.Нэр дэвшигчийн сонсголын асуулт, санал болон холбогдох мэдээлэл нь нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, туршлага, мэргэшил, ёс зүй, хараат бус, бие даан ажиллах чадвар, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлийн талаар байна.

10.4.Нэр дэвшигчийн сонсголотой холбогдуулан мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, иргэн, хэвлэл, мэдээллийн төлөөлөл оролцох хүсэлт гаргасан бол тэдгээрийг сонсголд заавал оролцуулна.”

## **3/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:**

“12.3.Сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих талаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг ажиглагч гэнэ. Ажиглагч нь сонсголын үед нэр дэвшигчээс болон бусад оролцогчдоос асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.”

#### **4/15 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүрэг:**

##### **“15 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүрэг**

15.1.Сонсголд оролцогч дараах нийтлэг эрх эдэлнэ:

15.1.1.энэ хууль болон холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх;

15.1.2.сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах;

15.1.3.сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах;

15.1.4.холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх эдлэх.

15.2.Сонсголд оролцогч дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

15.2.1.сонсгол зохион байгуулагчийн дуудснаар сонсголд хүрэлцэн ирэх;

15.2.2.сонсголын дэг сахих;

15.2.3.сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

15.2.4.сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх;

15.2.5.холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх.

15.3.Сонсголд оролцогч нь сонсголын явцад бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

15.4.Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.

15.5.Сонсгол зохион байгуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонсголд оролцох, ажиглах боломжийг хангана.”

5/17 дугаар зүйл.Сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг:

##### **“17 дугаар зүйл.Сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг**

17.1.Сонсгол даргалагч сонсголыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулах, сонсголын асуудлыг тал бүрээс нь үнэн бодитойгоор тогтоох, сонсголд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх, оролцогчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сонсголын дэг сахиулах үүрэгтэй.

17.2.Сонсгол даргалагчийг сонгох, томилох асуудлыг энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

17.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголын даргалагчийг Байнгын, дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.

17.4.Сонсгол даргалагч дараах нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

17.4.1.сонсголын бэлтгэлийг хангах;

17.4.2.сонсголыг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу явуулах;

17.4.3.сонсголд оролцож байгаа этгээдэд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;

17.4.4.сонсголын тайланг хянаж, эрх бүхий этгээдэд танилцуулах;

17.4.5.хүндэтгэн үзэх шалтгаантай оролцогчид чөлөө өгөх;

17.4.6.сонсголын дэг сахиулах, оролцогчдоос дэг сахихыг шаардах;

17.4.7.сонсголын дэг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах;

17.4.8.сонсголын асуулт, хариулт, тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох;

17.4.9.сонсголын дэг зөрчсөн, эсхүл энэ хуулийн 15.3-т заасан үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах;

17.4.10.сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх;

17.4.11.сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах.”

#### **6/18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг:**

“18.8.Сонсгол явуулах талаарх хүсэлт гаргах, тус хүсэлтийг шийдвэрлэх, сонсголын товыг зарлан мэдээлэх, сонсгол зохион байгуулах үйл явц, бүртгэл, сонсголын ирц, үе шат, сонсгол даргалагчийг сонгох, түүний эрх, үүрэг, сонсголын дэг болон сонсголын тэмдэглэл, тайлан гаргахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль<sup>[1]</sup> болон энэ хуулийн 18.7-д заасан журмаар нарийвчлан зохицуулна.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн” гэсний өмнө “мөн зүйлийн 18.7 дахь хэсгийн “батална.” гэснийг “баталж болно.” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-8 дэмжиж, 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 18.9 дэх хэсэг, төслийн 3 дугаар зүйлийн “10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “нийт гишүүний дөрөвний нэгээс” гэснийг “есөөс” гэж,” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-9 дэмжиж, 75 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулга бүхий 5 дугаар зүйл нэмэх:

“**5 дугаар зүйл.**Нийтийн сонсголын тухай хуулийн 11<sup>1</sup> дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-9 дэмжиж, 75 хувийн саналаар дэмжигдлээ.

## **ГУРАВ.ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

### **3.1.Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөнтэй холбоотой саналын томьёолол:**

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 15.33 дугаар зүйлийн гарчгийн “15.33 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтад саад учруулах” гэснийг “15.33 дугаар зүйл.Парламентыг үл хүндэтгэх” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт



12-9 дэмжиж, 75 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6.Энэ зүйлийн 1-5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан болон Улсын Их Хурлаас зохион байгуулах сонголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаан, сонголд оролцсон этгээд дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-8 дэмжиж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**ДӨРӨВ.ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**4.1.Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөнтэй холбоотой саналын томьёолол:**

1.Төслийн 3 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн” гэсний өмнө “8 дугаар зүйлийн 8.4.3 дахь хэсгийн “байгууллагад” гэснийг “байгууллага, Улсын Их Хуралд” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Санал хураалт

12-8 дэмжиж, 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хороо хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлах Сүхбаатар танилцуулна.

Дараагийн асуудалд оръё.

**Хоёр.Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай**

Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл

Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах үүрэг бүхий сонгон шалгаруулах комисс байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын талаарх хуулийн лавлагаа, тайлбар.

Төрийн албаны тухай хуулиас 68 дугаар зүйл зөвлөлийн гишүүн, 68.2. Та бүхэн сонсоорой.

Зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр нэг хүний, төрийн албан хаагчийн төлөөлөл хоёр хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд арван таваас доошгүй жил ажилласан, төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн, дээд боловсролтой, ял шийтгүүлж байгаагүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.

Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын төрийн байгуулалтын байнгын хороо батална гэж заасны дагуу Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журмыг батлах тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журмын 4.1-д заасны дагуу төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах комиссыг Улсын Их Хурлын төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын алба, Төрийн албаны зөвлөлийн ажлын алба, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Жендерийн үндэсний хорооны ажлын алба, Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газраас төрийн алба албанд хамгийн олон жил ажилласан удирдах албан тушаалтан, долоон хүний бүрэлдэхүүнтэйгээр Төрийн байгуулалтын байнгын хорооны шийдвэрээр байгуулна гэж заасан.

Үүний дагуу байгууллагуудаас санал авахад Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны зөвлөлийн Сургалт, судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын хэлтсийн дарга Санжрагчаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн хүний нөөцийн газрын дарга Отгонцэцэг, Жендерийн үндэсний хорооны ажлын албанаас Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Энхбаяр, Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллагаас Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор Алтанзул, Үндэсний аудитын газраас Үндэсний аудитын газрын аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг, Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комисоор Энхболд нарыг төрийн албанд хамгийн олон жил ажилласан удирдах албан тушаалтан гэж саналаа ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах, журмын 4.1-д заасныг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах үүрэг бүхий комисс байгуулах тогтоолын төслийг боловсруулсан.

Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоороо тогтоолоор баталсан. Төрийн албаны төлөөллийг төрийн албан хаагчийн төлөөлөгч сонгон шалгаруулах журмын 4.1-д заасныг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Комиссын дарга Хатантуул Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх,

Комиссын гишүүд Алтанзул Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, Наранчимэг Үндэсний аудитын газрын аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор, Отгонцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөцийн газрын дарга, Санжрагчаа Төрийн албаны зөвлөлийн сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын хэлтсийн дарга, Энхбаяр Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, Энхболд Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий комиссын нарийн бичгийн даргаар комиссын гишүүн Санжрагчааг томилсугай.

3.Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчдын төлөөллийг сонгон шалгаруулах журамд нийцүүлэн явуулж, дүнг Төрийн байгуулалтын байнгын хороонд 2021 оны 12 дугаар сарын 28-ны дотор ирүүлэхийг комисс /Б.Хатантуул/-т үүрэг болгосугай.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Мөнхбат гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбоотой асуудал саналтай гишүүн байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя, тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор.

Санал хураалт

12-8 дэмжиж, 66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Ингээд Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын албанд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ